



ЗҮҮН БҮСИЙН ДОРНОД АЙМГИЙН СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН ҮЗЛЭГ, СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Тайлан бичсэн:

А.Дүүрэнжаргал

Бурхан Халдун уул түүнийг хүрээлсэн тахилгат газар нутгийн хамгаалалтын захиргааны судалгаа, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн

Улаанбаатар хот

2022 он

Энэхүү тайланг Монгол улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл Урлагийн газрын захилгаар “СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН ҮЗЛЭГ, БҮСЧИЛСЭН СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗҮҮН БҮСИЙН ХЭЭРИЙН СУДАЛГАА” сэдэвт ажлын хүрээнд хийж гүйцэтгэв.

Судалгааны багийн ахлагч: А.Дүүрэнжаргал (Бурхан Халдун уул түүнийг хүрээлсэн тахилгат газар нутгийн хамгаалалтын захиргааны судалгаа, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн)

Судалгааны багийн гишүүд:

С.Мижид (ЭША, НСИСОУХ),

Ч.Должинсүрэн (Соёлын өвийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Дорнод аймгийн соёл урлагийн газар),

Зураглаач: Б.Мөнхбаатар (Компьютер графикч, СӨҮТ)

Жолооч: Ч.Хишигбат

Талархал

“Зүүн бүсийн соёлын биет бус өвийн үзлэг, судалгаа”-ны ажлыг итгэл хүлээлгэн даалгаж, бүх талаар тусалж дэмжсэн Монгол улсын Соёлын яамны соёлын өвийн газар, Монгол улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг соёл урлагийн газар, Соёлын өвийн үндэсний төвийн хамт олонд талархал илэрхийлье. Судалгааны бүхий л шатанд бүх талын дэмжлэг үзүүлж, өөрсдийн үнэтэй зөвлөгөө, зөвлөмж, дэмжлэг үзүүлж, тав тухтай судалгаа хийх боломж, нөхцөлөөр хангасан явдалд баярлалаа.

Мөн судалгаа хийх бүх талын дэмжлэг үзүүлж, шуурхай удирдлагаар хангаж, өөрийн санал зөвлөмж, бүх талын дэмжлэг туслалцаа, үзүүлэн хамтран ажилласан Дорнод аймгийн соёл, урлагийн газрын хамт олон болон соёлын хэлтсийн ахлах мэргэжилтэн Л.Идэрбат нарт талархал илэрхийлж байна.

Үүнээс гадна судалгааны явцад бүхий л талаар дэмжиж тусалсанд, Халхгол сумын соёлын төвийн хамт олон, Матад сумын соёлын төвийн хамт олон, Хэрлэн сумын соёлын төвийн хамт олон, Чойбалсан сумын соёлын төвийн хамт олон, Гурванзагал сумын соёлын төвийн хамт олон, Чулуунхороот сумын соёлын төвийн хамт олон, тус сумын нийгмийн ажилтан Н.Одсүрэн, Дашбалбар сумын соёлын төвийн хамт олон, Баяндун сумын соёлын төвийн хамт олон, Баян-Уул сумын соёлын төвийн хамт олон, Цагаан-Овоо сумын соёлын төвийн хамт олон, Сэргэлэн сумын соёлын төвийн хамт олон, Баянтүмэн сумын соёлын төвийн хамт олон, Булган сумын соёлын төвийн хамт олон, Хөлөнбуйр сумын соёлын төвийн хамт олонд тус тус тусгайлан гүн талархал илэрхийлье.

Хамгийн чухал нь соёлын биет бус өвийн үзлэг, соёлын биет бус өвийн болон түүнийг өвлөн уламжлагчдын өнөөгийн нөхцөл байдал, түүнд нөлөөлж буй хүчин зүйлс, тархалтын хүрээг тодорхойлох, дүн шинжилгээ хийх зорилго бүхий энэхүү судалгаанд өөрсдийн мэдлэг, онцгой ур чадвар, амьдралын хэвшил, дадал, нөхцөл байдлынхаа тухай харамгүй сэтгэлээр тус хүргэсэн нийт судалгаанд хамрагдсан Дорнод аймгийн соёлын биет бус өвийн өвлөн уламжлагч нартаа чин сэтгэлийн талархал илэрхийлж, амьдралд нь аз жаргал, амжилт бүтээл, хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Баярлалаа.

**ГАРЧИГ
ТАЛАРХАЛ**

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Удиртгал

1.1 Судалгааны үндэслэл.....	5
1.2 Судалгааны ажлын зорилго, зорилт	5
1.3 Судалгааны арга зүй	6
1.4 Судалгааны тойм.....	7
1.5 Судалгааны хамрах хүрээ, маршрут, багийн бүрэлдэхүүн.....	9
1.8 Дүгнэлт: Хэнтий аймагт ажилласан СББӨ-ийн улсын үзлэг, судалгааны үр дүн (зорилго, зорилтын биелэлт).....	11

**2. ДОРНОД АЙМГИЙН СОЁЛЫН БИЕТ БУС ӨВ, ӨВЛӨН УЛАМЖЛАГЧИД
ХИЙСЭН ЦАХИМ СУДАЛГААНЫ (GOOGLE FORMS) ҮЗҮҮЛЭЛТ**

2.1 Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын угсаатны бүлгийн онцлог	15
2.2 Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын нийгмийн асуудал	20
2.3, Соёлын биет бус өвийн оршин тогтнох чадварыг тодорхойлох судалгаа.....	30
2.4, Соёлын биет бус өвд эерэг болон сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийн судалгаа	35
2.5, Соёлын биет өв өвлөн уламжлагчдын ургийн бичиг хөтлөлтийн асуудал.....	38
2.6, Дүгнэлт: Соёлын биет бус өвийн өнөөгийн байдал ба соёлын бие бус өвийн өвлөн уламжлагчдын оршихуй.....	40

**ГУРАВДУГААР БҮЛЭГ: ДОРНОД АЙМАГТ ХИЙСЭН СОЁЛЫН
БИЕТ БУС ӨВИЙН ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮН**

3.1 Судалгааны дүн мэдээ	42
--------------------------------	----

ХАВСРАЛТ **93**

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

1.1 Судалгааны үндэслэл

Хүн төрөлхтөн оршин буй хугацаандаа хоёр том иргэншил буй болгосны нэг нь нүүдлийн соёл иргэншил юм. Тэрхүү соёл иргэншлийн нэг том багана нь Монгол улс, Монголын төвт нүүдлийн соёл иргэншил юм. Дэлхий дахинаа соёлын даяаршил, ижилсэл хүчтэй өрнөж буй өнөө үед улс орон бүр соёлын бодлогодоо хөрөнгө хүч, анхаарал үлэмж хандлуулах боллоо. Үүний тод илэрхийлэл бол Монгол улсын хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичиг “алсын хараа-2050”-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.2.7. *“Дэлхийн нүүдлийн соёл, иргэншлийн голомт” байгууллагыг байгуулж, дэлхийн нүүдэлчдийн төв болох цогц хөтөлбөрийг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хэрэгжүүлнэ*” хэмээн заасан байна. Энэ бодлогын хэрэгжилтийн хүрээнд соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.11 дэх хэсэг, 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт, Соёлын сайдын 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн “Зардал баталж, эрх шилжүүлэх тухай” А/218 дугаар тушаалыг үндэслэн “соёлын биет бус өвийн үзлэг, судалгаа” сэдэвт ажлыг Дорнод аймагт зохион байгуулав.

Бид соёлын биет бус өв (СББӨ)-ийн судалгаандаа 7 ай савын хүрээнд дараах гурван асуудлыг авч үзэв. Үүнд, нэгт, соёлын биет бус өвлөн уламжлагчдын өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх. Хоёрт, биет бус өвийн өнөөгийн нөхцөл байдалд эерэг болон сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлс, түүний учир шалтгааныг тодорхойлох. Гуравт, соёлын биет бус өвийн онцлог, бүс нутгийн онцлогт нийцүүлэн авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлоход зэрэгт анхаарч ажиллав.

1.2 Судалгааны ажлын зорилго, зорилт

Дорнод аймгийн соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ өгөх, одоогийн нөхцөл байдлыг тодорхойлоход оршив. Монгол улсын зүүн бүс нутагт соёлын биет бус өвийн үзлэг, судалгаа зохион байгуулах удирдамжид үндэслэн дараах зорилтыг судалгааны ажлын удиртгал болгов.

- 1) СББӨ-ийн уламжилж буй байдал, шилжилт хөдөлгөөн, нийгэм, эдийн засаг, эрүүл мэндийн нөхцөл байдлын судалгаа хийх;

- 2) Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Бүртгэл шинэчлэн батлах тухай” 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/759 дүгээр тушаалаар баталсан Соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэл, Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэлд бүртгэгдсэн өв, өвлөн уламжлагчийн талаар түүвэр судалгаа хийх;
- 3) Тухайн орон нутагт оршин буй үндэстэн, угсаатны бүлэг, СББӨ-ийн төрөл зүйлийг таньж тогтоох, сурвалжлан олох;
- 4) Соёлын биет бус өв, өв тус бүрийн хадгалалт хамгаалалтын өнөөгийн нөхцөл байдал, эерэг болон сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг илрүүлж тогтоох, дүн шинжилгээ хийх;
- 5) СББӨ болон өвлөн уламжлагчийн тоо, газарзүйн тархалтыг тогтоох;
- 6) Тухайн орон нутагт СББӨ-ийн чиглэлээр зохион байгуулагдсан арга хэмжээний мэдээллийг цуглуулах;
- 7) СББӨ-ийн үзлэг, судалгааны үр дүнгийн талаарх урьдчилсан дүгнэлт гаргах;
- 8) Судалгаа хийсэн СББӨ-ийг төлөөллийн болон яаралтай хамгаалах жагсаалтад оруулах, хасах, хадгалан хамгаалах санал боловсруулах;
- 9) Үзлэг, судалгааны мөрөөр авах арга хэмжээний санал боловсруулах;
- 10) СББӨ түүнийг өвлөн уламжлагчийг гэрэл зураг, дуу, дүрс бичлэгээр баримтжуулж, Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санг баяжуулах.

1.3 Судалгааны арга зүй

Судалгааны арга зүйн тухайд судалгааны удирдамжийн 5.6.1 СББӨ-ийн үзлэг, бүсчилсэн судалгаа хийх “хээрийн судалгааны баг” маршрутын дагуу орон нутагт ажиллахдаа түүврийн болон асуумжийн арга зүйг ашиглана хэмээн заасныг үндэслэн нийгэм соёлын антропологи шинжлэх ухааны судалгааны ярилцлага, ажиглалт хийх аргыг уг судалгааны ажлын гол чиг баримжаа болгов. Судалгааны оролцогчдыг сонгохдоо улсын бүртгэл мэдээллийн сан (УНБМС)-д бүртгэлтэй өвлөн уламжлагчдаас түүврийн аргаар сонгон авч судалгаа хийв. Мөн сум тус бүрийн онцлогийг харгалзан үзэж, магадлалт түүврийн аргыг ашиглан өвийн төрөл, өвлөн уламжлагч нарыг сонгож, судалгаанд хамруулав. Судалгаа авахдаа өвлөн уламжлагч тус бүрээр бүлгийн болон ганцаарчилсан ярилцлага хийж дүрс бичлэг, зургаар баримтжуулав. Соёлын биет бус өвийн 7 ай савын хүрээнд УНБМС-д бүртгэлгүй өвлөн уламжлагчдыг судалгаанд хамруулан шинээр бүртгэв. Харин судалгааны

задлан шинжилгээний хувьд антропологийн этнографийн судалгааны түвшинд өргөн хэрэглэгддэг тайлан тайлбарлах (interpretation) арга (Geertz 1973)-ыг тайлангийнхаа үндсэн чиг баримжаа болголоо.

1.4 Судалгааны тойм (Дорнод аймагт хийгдсэн биет бус өвийн судалгаа)

Соёлын биет бус өвийн судалгааг хоёр хэсэгт хуваан үзэж болмоор байна. Нэгдүгээрт, Соёлын өвийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагын бүртгэл, судалгаа. Энэ судалгаа нь өвийг хамгаалахад үйл ажиллагаа нь голчлон чиглэгдсэн байна. Хоёрдугаарт, Монгол улсын шинжлэх ухааны байгууллагын судалгаа. Энэ судалгаа нь эрдэм шинжилгээний бүтээл, эмхэтгэл гаргахад голчлон чиглэгддэг байна.

СББӨ-ийн судалгааг Соёлын өвийн үндэсний төв, бусад байгууллагуудтай хамтран олон удаа хийж байжээ. Үүнээс “Зүүн бүсийн соёлын биет бус өвийн судалгааг 2017 онд Хэнтий аймгийн Биндэр, Дадал, Батноров, Норовлин, Батширээт зэрэг суманд, Дорнод аймгийн Сэргэлэн, Булган, Хөлөнбуйр, Гурванзагал, Цагаан-овоо, Дашбалбар зэрэг суманд, Сүхбаатар аймгийн Баруун-Урт, Дарьганга, Эрдэнэцагаан, Түвшинширээ, Уулбаян, Баяндэлгэр зэрэг суманд зохион байгуулсан байна. Дорнод аймагт хийсэн тус судалгаа нь тус аймагт орших угсаатны бүлгийн онцлог бүхий соёлд анхаарал хандуулан, Буриад, Барга, Үзэмчин зэрэг угсаатны бүлгийн СББӨ-ийг олж тогтоох, түүний дотор “эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд”, “уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага”, “байгалийн болон сав шим ертөнцийн тухай мэдлэг, зан үйл” зэрэг ай савд хамрах өвийн зүйлсийг илрүүлэх, бүртгэх, баримтжуулах үндсэн чиг үүрэгтэй ажиллажээ. Тус судалгаанд нийт 33 өвлөн уламжлагч харагдсан байх бөгөөд СББӨ-ийн 18 төрөл зүйлийг баримтжуулсан байна. Тус судалгаа нь СББӨ-ийг бүртгэх, баримтжуулах чиглэлээр хийсэн томоохон судалгааны нэг байна.

Шинжлэх ухааны байгууллагаас хийсэн зарим хээрийн судалгааны эх хэрэглэгдэхүүний тухайд 1973 онд Ц.Аюуш Дорнод аймгийн Матад суманд Хатгитган халхчуудын оюуны болон эдийн соёл, түүнд хамаарах уламжлалт мал аж ахуй, нүүдэллэх арга, ан ав хийх арга барил, үйлдэх зан үйл, хэв ёс, гэр зуурын үйлдвэрлэлийн онцлог, орон сууц хийх, түүний дотор засал тавил, хувцас хунар, хуримын зан үйл зэргийг сурвалжлан судалжээ (Аюуш.Ц 2020, 56). Мөн онд Г.Батнасан Дорнод аймгийн Цагаан-овоо, Галуут, Сэргэлэн,

Дашбалбар сумдад мөн хээрийн судалгаа хийж нэгдэлж малчдын ахуй амьдрал, соёлын өвийн тухай сонирхолтой судалгаа хийсэн байна (Чулуун.С, Цэрэнханд.Г, Булаг.У 2011, 145).

Мөн онд Г.Цэрэнханд Дорнод аймгийн Дашбалбар, Цагаан овоо, Гурванзагал, Хөлөнбуйр, Сэргэлэн сумдад нэгдэлч малчдын ахуй соёлын тухай нэн сонин мэдээ баримт цуглуулжээ (Чулуун.С, Цэрэнханд.Г, Булаг.У 2011, 282).

1976 онд Г.Батнасан Дорнод аймгийн Буриад сумдын хүрээнд судалгаа хийж, буриад хувцас хэрэглэл, гоёл чимэглэл, түүнийг хийх арга ажиллагааны тухай буюу дархны урлал, хоол хүнс, ахуй соёл, эмээл хазаар, хөсөг тэрэг, сав суулга, мал маллах арга ажиллагаа, хуримын зан үйл зэргийн тухай судалгаа хийсэн (Чулуун.С, Цэрэнханд.Г, Булаг.У 2011, 234) бол Ц.Аюуш Дорнод аймгийн Сэргэлэн, Дашбалбар, суманд мөн угсаатны зүйн хээрийн судалгаа хийж байжээ. Тэрээр Дорнод аймгийн Сэргэлэн сумын Үзэмчин нараас Өвөр Монголоос хэрхэн нүүж ирсэн тухай, нүүдлийн байр байдал, ямар ямар газраар дамжиж ирсэн тухай тэмдэглэж авснаас гадна хурмын зан үйл, гал тахилга, бөхийн барилдаан, цагаан сарын баяр, оршуулга зэргийг сурвалжилжээ. Хамгийн чухал дээрх зан үйлүүд хэрхэн өөрчлөгдөж буй тухай мөн яриа авсан байна. Мөн Чингисийн сүлдний тахилгын тухай мэдээд сурвалжлан тэмдэглэсэн байна. Харин Дашбалбар суманд 17 хүнтэй уулзаж, буриадын соёл, заншлын тухай мэдээ авчжээ. Голлон буриад хурмын зан үйлийг сурвалжлан тэмдэглэсэн байна (Аюуш.Ц 2020, 104).


1984 онд С.Бадамхатан, Т.Дисан нар “төв баруун, өмнөд халх”-ын судалгааны хүрээнд Дорнод, Хэнтий аймагт оюуны болон эдийн соёлын судалгаа хийсэн байна. Бадамхатан гуай Дорнод, Хэнтий аймгийн иргэдийн дунд овгийн судалгаанд ихээхэн анхаарал хандуулсан (Чулуун.С, Цэрэнханд.Г, Булаг.У 2011, 4) бол Т.Дисан Халхын зүүн хэсэг дэх ардын уламжлалт гар урлалын зарим төрөл болох мод, дарх, оёмол хатгамлын урлалын хөгжиж ирсэн түүхэн онцлогийг угсаатны зүйн аргачлалаар ажиглаж судалсан (Чулуун.С, Цэрэнханд.Г, Булаг.У 2011, 24) байна. Тус судалгааны ажлын үргэлжлүүлэн 1985 онд С.Бадамхатан, Г. Мэнэс нар Хэнтий, Дорнод аймагт хээрийн судалгаа хийж байжээ (Чулуун.С, Цэрэнханд.Г, Булаг.У 2011, 152). Энэ мэт соёлын биет бус өвийн талаар хийгдсэн судалгаа нэн элбэг байна. Харин


бидний хийж буй тус судалгаан нь СББӨ-ийг бүртгэх, баримтжуулах үндсэн чиг үүрэг бүхий судалгаа болно.

1.5 Судалгааны хамрах хүрээ, маршрут, багийн бүрэлдэхүүн

Дорнод аймгийн 14 суманд ажиллаж соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчдыг бүртгэн баримтжуулав. (зураг:01). Хээрийн судалгааны багийн ахлагч А. Дүүрэнжаргал (Бурхан Халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутгийн хамгаалалтын захиргаанд судалгаа, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн) судлаач С.Мижид (ЭША, ЮНЕСКО-ийн ивээл дор НСИСОУХ), судлаач Ч.Должинсүрэн (Дорнод аймгийн Соёл урлагийн газарт Соёлын өвийн асуудал хариуцсан мэргэжилтэн,) зураглаач Б.Мөнхбаатар (СӨҮТ-ийн Мэдээллийн технологийн газарт Компьютер графикч,) жолооч Ч.Хишигбат нар ажиллав.

Соёлын биет бус өвийн үзлэг, хээрийн судалгааны ажлыг Дорнод аймгийн 14 суманд дараах маршрутын дагуу 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрөөс 11 сарын 06 хүртэл 24 хоногийн хугацаанд зохион байгуулав. Нийт 3490 км зам туулав.





ДОРНОД АЙМГИЙН СУМААР ЯВСАН МАРШРУТ

Сумын нэр		Явсан зам	Хугацаа
1	Халхгол сум	УБ-655км Хэрлэн-350 кмХалх гол	10/15-17
2	Матад сум	Халх гол- 300км Матад сум	10/17-18
3	Хэрлэн сум (Чойбалсан хот)	Матад сум-200км Хэрлэн сум	10/18-19
4	Чойбалсан сум	Хэрлэн сум- 80км Чойбалсан сум	10/19-20
5	Гурванзагал сум	Чойбалсан сум- 60км Гурванзагал сум	10/20-23
6	Чулуунхороот сум	Гурванзагал сум- 150км Чулуунхороот сум	10/23-25
7	Дашбалбар сум	Чулуунхороот сум- 160км Дашбалбар сум	10/25-27
8	Баяндун сум	Дашбалбар сум-195км Баяндун сум	10/27-29
9	Баян-Уул сум	Баяндун сум- 130км Баян-Уул сум	10/29-31
10	Цагаан-Овоо сум	Баян-Уул сум- 110км Цагаан-Овоо сум	10/31-11/1
11	Сэргэлэн сум	Цагаан-Овоо сум- 150км Сэргэлэн сум	11/1-3
12	Баянтүмэн сум	Сэргэлэн сум- 150 км Баянтүмэн сум	11/3-11/4
13	Булган сум	Баянтүмэн сум-90км Булган сум	11/4-5
14	Хөлөнбуйр	Булган сум-110км Хөлөнбуйр-600км- Улаанбаатар	11/5-6
Нийт		3490 км	24 хоног

1.8 Дүгнэлт: Хэнтий аймагт ажилласан СББӨ-ийн улсын үзлэг, судалгааны үр дүн (зорилго, зорилтын биелэлт)

Судалгааны ажлын үр дүнг ажлын даалгавар, судалгааны ажлын удирдамжид үндэслэн доорх байдлаар гаргав.

1	СББӨ-ийн уламжилсан байдал, шилжилт хөдөлгөөн, нийгэм, эдийн засаг, эрүүл мэндийн нөхцөл байдлын судалгаа хийх;	-Дорнод аймгийн байгаль орчин, нөөц баялаг, сумдын онцлог зэрэгтэй танилцаж мэдээлэл бүрдүүлсэн, -СББӨ-ийн өмнөх цаг үеийн мэдээллүүдтэй танилцсан, -14 сумын соёлын төв болон засаг захиргааны удирдлагуудтай уулзаж өнөөгийн нөхцөл байдлын талаар тодруулга авч, заримд нь зөвлөгөө өгч ажиллав. -СББӨ-ийн 111 өвлөн уламжлагчаас цаасан болон цахим судалгааг авч 78 өвлөн уламжлагчийн судалгааг онлайн хэлбэрт бүртгүүлэв.
2.2.	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Бүртгэл шинэчлэн батлах тухай” 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/759 дүгээр тушаалаар баталсан Соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэл, Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэлд бүртгэгдсэн өв, өвлөн уламжлагчийн талаар түүвэр судалгаа хийх;	-Үндэсний бүртгэлд шинээр нэмж оруулах болон хасах саналтай өвлөн уламжлагчдын мэдээлэлтэй танилцах ажлыг хийв. Сум тус бүрийн анхан шатны СББӨ-ийн бүртгэлтэй танилцсан. - Улсын бүртгэлд бүртгэгдсэн Дорнод аймгийн 96 өвийн 337 өвлөн уламжлагчдаас 7 айн 83 өвөөс 4 айн 9 өв, Монгол улсын соёлын биет бус өвийн төлөөллийн үндэсний бүртгэл байх нийт 7 айн 279 өвөөс 7 айн 63 өв тус тус бүртгэл судалгаанд хамруулав.
2.3.	Тухайн орон нутагт оршин буй үндэстэн, угсаатны бүлэг,	-Дорнод аймгийн Цагаан-овоо сумын Буриад хуримын зан үйлийг

	СББӨ-ийн төрөл зүйлийг таньж тогтоох, сурвалжлан олох;	баримтжуулсан. -СББӨ-ийг өвлөн уламжлагчдыг нэмж тодруулав.
2.4.	Соёлын биет бус өв, өв тус бүрийн хадгалалт хамгаалалтын өнөөгийн нөхцөл байдал, эерэг болон сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг илрүүлж тогтоох, дүн шинжилгээ хийх;	-СББӨ-ийн хадгалалт хамгаалалтын өнөөгийн нөхцөл байдалд, эерэг болон сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг асуулга болон ярилцлагын аргаар тодруулав. -14 сумын соёлын төвийн дарга, сум тус бүрд сумын түүх, соёл, онцлогийн талаар тухайлсан хүнээс ярилцлага авч, аудио эх хэрэглэгдэхүүн бүрдүүлсэн.
2.5.	СББӨ болон өвлөн уламжлагчийн тоо, газарзүйн тархалтыг тогтоох;	Тайлангийн 2-р бүлгийн 2.2, 2.3 үзнэ үү.
2.6.	Тухайн орон нутагт СББӨ-ийн чиглэлээр зохион байгуулагдсан арга хэмжээний мэдээллийг цуглуулах;	Хавсралтаас үзнэ үү.
2.7.	СББӨ-ийн үзлэг, судалгааны үр дүнгийн талаарх урьдчилсан дүгнэлт гаргах;	Тайлангийн 3.3 дэд бүлгээс үзнэ үү.
2.8.	Судалгаа хийсэн СББӨ-ийг төлөөллийн болон яаралтай хамгаалах жагсаалтад оруулах, хасах, хадгалан хамгаалах санал боловсруулах;	Тайлангийн 2-р бүлгийн 2.1, 3 дугаар бүлгээс үзнэ үү.
2.9.	Үзлэг, судалгааны мөрөөр авах арга хэмжээний санал боловсруулах;	Тайлангийн гуравдугаар бүлэг, 3,3 зүйлээс үзнэ үү

2.10.	СББӨ, өвлөн уламжлагчийг гэрэл зураг, дуу, дүрс бичлэгээр баримтжуулж, Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санг баяжуулах.	<p>Нийт 127 минут 8 секундйн хугацаатай үргэлжлэх 232.5 MB дуу бичлэг, 113.5 GB хэмжээтэй 1481 гэрэл зураг болон 1835.3 минут буюу 30.5 цагийн хугацаатай үргэлжлэх 582 GB хэмжээтэй дүрс бичлэг бүрдүүлээ.</p> <p>Нийт файлын хэмжээ 3964 ширхэг бүхий 703 GB боллоо.</p> <p>Зураг авалтад ашигласан тоног төхөөрөмж</p> <ul style="list-style-type: none"> • Дуу бичлэгийг Zoom H6 ашиглан MP3 форматаар • Дүрс бичлэгийг GoPro Hero 9, Nikon D850, Nikon D7000 ашиглан Full HD 1080 болон 4K нягтаршил бүхий MOV, MP4 форматаар • Гэрэл зургийг Nikon D850, Nikon D7000 ашиглан JPEG, RAW форматаар <p>ашиглан авлаа.</p> <p>Эдгээр ажлын файлуудыг тухайн төхөөрөмжүүдийн дээд хүчин чадалд тулгаж авсан бөгөөд цаашид бүтээл болгон ашиглахад хангалттай өндөр чанартай болно.</p> <p>Тайлангийн 3,3 хэсгийг үзнэ үү, Хавсралт хэсгийн товъёг үзнэ үү</p>
-------	--	---

2. ДОРНОД АЙМГИЙН СОЁЛЫН БИЕТ БУС ӨВ, ӨВЛӨН УЛАМЖЛАГЧИД ХИЙСЭН ЦАХИМ СУДАЛГААНЫ (GOOGLE FORMS) ҮЗҮҮЛЭЛТ


Соёлын өв, түүнийг өвлөн уламжлагчдын өнөөгийн нөхцөл байдлыг тандан судлах, түүнд үнэлэлт дүгнэлт өгөх ажлыг судалгааны түвшинд анх удаа хийж байна. Энэ хүрээнд бид өвлөн уламжлагчдын хүйс, нас, угсаатны бүлэг, тухайн өвлөн уламжлагчдын хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн байдал орлогын эх үүсвэр, тухайн хүний өвлөн уламжилж буй өв нь өрхийн эдийн засагт санхүүгийн хувь ямар үр нөлөөтэй байна вэ гэдгийг энэ хэсэгт нягтлан авч үзлээ. Бид дээрх асуудлыг тоон судалгааны үр болон ажиглалт, ярилцлагын аргаар цуглуулсан эх хэрэглэгдэхүүний хүрээнд дүн шинжилгээ хийв.

Дорнод аймгаас СББӨ-ийн өвлөн уламжлагч нийт 78 өвлөн уламжлагчийн 72 өвийн төрөл зүйл бүргэгдэв. Үүнд: Монгол улсын яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэл байх 7 айн 83 өвөөс 4 айн 9 өв бүртгэгдлээ. Бид соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын өнөөгийн байдлыг тодорхойлох үндсэн үүргийнхээ хүрээнд бид тоон судалгааны үр дүнг, ажиглалтын ярилцлагын аргаар авсан мэдээлэл тулгуурлан дүн шинжилгээ хийх байна. Бид Дорнод аймгийн хэмжээнд УНБМС-нд бүртгэлтэй өвлөн уламжлагчдын мэдээлэлд тулгуурлан судалгаанд оролцогч өвлөн уламжлагчдаа сонгосон бөгөөд 7 ай савд хамаарах бүртгэлгүй өвлөн уламжлагчдтай мөн уулзаж, ярилцлага авсан болно.

Бидний судалгаанд хамрагдсан өвлөн уламжлагчдын 57.3 хувь нь орон нутгийн соёлын өвийн ажилтны таньж тогтоосноор бүртгэгдсэн өвлөн уламжлагчид бөгөөд 38.7 хувь нь буюу 29 өвлөн уламжлагчдыг судалгааны багийн гишүүд ярилцаж, шинээр бүртгэсэн болно (зураг:10). Цаашид соёлын биет бус өв өвлөн уламжлагчдыг тухайлсан чиглэлийн нарийн мэргэжлийн судлаачдын дүгнэлтээр бүртгэдэг байх чухал хэмээн үзэж байна.

2.1 Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын угсаатны бүлгийн онцлог

Дорнод аймаг нь соёлын онцлогийн хувьд Халх, Буриад, Үзэмчин, Барга угсаатны бүлэг болон Монгол улсын 2 аймгийн хүн ам их бага хэмжээгээр оршин суудаг бүс нутаг юм. Мөн урагшаагаа БНХАУ-ын ӨМӨЗО-ны Барга, Буриад, Үзэмчин зэрэг угсаатны бүлэгтэй хиллэдэг. Хойд талаараа ОХУ-ын Буриад, Барга зэрэг угсаатны бүлэгтэй соёлын хувьд нягт харилцаатай байна. Тухайлбал судалгаанд хамрагдсан өвлөн уламжлагчдын угсаатны бүлгээр ангилан үзэхэд (зураг:01) Халх угсаатны бүлгийн төлөөлөл нийт судалгаанд өвлөн уламжлагчдын 44% хувийг эзэлж байсан бол Буриад угсаатны бүлгээс 25 өвлөн уламжлагч, Барга угсаатны бүлгээс 9 өвлөн уламжлагч, Үзэмчин угсаатны бүлгээс 6 өвлөн уламжлагч уг судалгаанд хамрагдсан байна.



Дорнод аймаг 2020 оны байдлаар 82,000 орчин хүн амтай бөгөөд угсаатны бүлгийн хувьд халх угсаатны бүлэг 58,000 орчим хүн амтай буюу 70

Үндэс, угсаа	2010*		2020*	
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь
МОНГОЛ УЛСЫН ХАРЬЯАТ -БҮГД	68 589	100.0	81 228	100.0
Халх	46 478	67.8	57 139	70.3
Казах	72	0.1	90	0.1
Дөрвөд	389	0.6	465	0.6
Баяд	140	0.2	177	0.2
Буриад	15 960	23.3	16 905	20.8
Захчин	159	0.2	172	0.2
Дарьганга	857	1.3	1 733	2.1
Урианхай	91	0.1	97	0.1
Дархад	225	0.3	196	0.3
Торгууд	101	0.1	102	0.2
Мянгад	41	0.1	85	0.1
Барга	1 989	2.9	1 905	2.3
Үзэмчин	1 856	2.7	1 702	2.1
Сартуул	6	-	65	0.1
Хамниган	97	0.1	252	0.3
Бусад үндэстэн	109	0.2	111	0.2
Монголын харьяат бусад үндэстэн	19	-	32	-

*Гадаадад оршин суугаа Монгол Улсын иргэдийн тоо ороогүй

Зураг: 02, Дорнод аймгийн хүн амын бүтэц угсаатны бүлгээр

хувь, буриад 17,000 орчим 20 хувь, Барга угсаатны бүлэг 1,900, Үзэмчин угсаатны бүлэг 1,700 орчим буюу 2 хувийг эзэлж байна. Гэвч Дорнод аймгийн соёл өвийн хувьд Халх, Буриад, Үзэмчин, Барга угсаатны бүлэгт суурилсан өв ихээхэн онцлогтой байна. Учир нь дээрх угсаатны түүх, соёлын уламжлалд тулгуурласан соёлын наадмууд нь СББӨ-ийг нөхцөлдүүлж байдаг бөгөөд соёлын өвийг хадгалалт хамгаалалтыг идэвхжүүлэгч, өдөөгч хүчин зүйл болж байна. Яг л идэш тэжээлийн гинжин хэлхээ гэдэг шиг соёлын өвийн оршин тогтнох, хөгжих, түгээн дэлгэрэх боломж нь угсаатны бүлэгт суурилсан соёлын наадмууд ихээхэн үүрэгтэй байгаа нь судалгааны явцад ажиглагдаж байв.

Ер нь угсаатны бүлэгт суурилсан соёл нь өв соёлыг хадгалж хамгаалах, сэргээхэд яг л хүнс тэжээлийн гинжин хэлхээ гэдэг шиг соёлын өвийн гинжин хэлхээ болж бэхэлж, зангидаж өгч байдаг аж. Тухайлбал, Буриадын угсаатны бүлгийн хувьд “Алтаргана”, Үзэмчин угсаатны бүлгийн хувьд “Алтан дөрөө”, Барга угсаатны хувьд “Баргажин”, хатиган нарын хувьд “Хатиган” зэрэг соёлын наадмууд нь иргэдийн соёл, ухамсрыг сэргээхэд ихээхэн ач холбогдолтой байна. Тухайлбал, үндэсний хувцас хэрэглэл сэргэх, мал аж ахуйд суурилсан соёлын олон айг тогтоон барих, хөгжүүлэхэд үндсэн багана, түшиг тулгуур болж байна. Эдгээр наадам СББӨ-ийн хадгалалт, хамгаалалт хэрхэн нөлөөлж байгааг товч авч үзэе

“Алтаргана” соёлын наадам: Буриад түмний алтаргана наадам хоёр жилд нэг удаа зохион байгуулагддаг. Анх 1994 онд Хэнтий аймгийн Дадал

суманд Буриад дууны уралдаан нэртэйгээр анх зохиогдож байсан тус наадам өдгөө олон улсыг хамарсан буриадын урлаг, уламжлалт зан заншлын баяр болж өргөжсөн байна. Улмаар 2000 онд Дашбалбар суманд болсон Алтаргана наадамд Эрхүүгийн баруун буриадууд, Улаан-Үүдийн агийн буриадаас зочид төлөөлөгч нар хүрэлцэн ирснээр уг наадам олон улсын нэр хүндтэй томоохон наадам болох эхлэл тавигджээ. Эдүгээ ОХУ-ын Буриадын Бүгд найрамдах улс, БНХАУ-ын Өвөр Монголын Өртөө Засах Орноос буриадууд хүрэлцэн ирж оролцон гадна гурван улс (Монгол, Орос, БНХАУ) ээлжлэн 2 жил тутамд зохион байгуулагдаж байна. Уг наадмын тухай Дорнод аймгийн Дашбалбар сумын иргэн М.Б ийнхүү ярив.

“...Алтаргана наадмын гол зорилго хуучин өв уламжлалаа сэргээх, хүүхэд багачуудыг өвөг, дээдэс соёлоороо бахархах сэтгэлийг төлөвшүүлэхэд оршдог. Нутгийн буурлууд хэлэхдээ “нэг үе бид Буриад гэж хэлэхээсээ эмээдэг байлаа” хэмээн хуучилдаг байсан. Уг наадмын нөлөөгөөр найман настай балчраас наян настай буурлууд хүртэл угсаатны онцлог бүхий дээл хувцсаа өмсөж байна. Энэ бол нэг том үр дүн гэж бид харж байна. Ер нь ЮНЕСКО-ийн соёлын талаар баримтлах бодлогот соёлын өвөрмөц байдлыг хадгалж, хамгаалан хэмээн тусгасан байдаг. Энэ үзэл баримтлалтай Алтаргана наадмын үзэл санаатай нийцэж байгаа юм...¹”.

Харин Дорнод аймгийн Цагаан-овоо сумын иргэн С.Б уг наадмын тухай ийнхүү хуучлав.

“...Ер нь ард түмний хувьд Буриад ч бай, Халх ч бай. Хэрэв соёл уламжлалгүй бол юу болох вэ? Юунд итгэл, найдвар өгч ажиллаж амьдрах вэ? амьдрал ямар утга учиртай вэ гэх мэт олон асуудал байна. Энэ өргөн утгаараа бол Монгол улсын дэлхийд хэн байх вэ? Дэлхий олон улсаас соёлын хувьд юугаараа онцлог байх вэ гэдэг асуудалтай шууд холбогддог. Ер нь биднийг хэн юм, хэрхэн ажилж, амьдрах ёстойг энэ наадмаас бид санаж, ухаардаг. Даарч яваад зузаан дээл өмсөх ямар сайхан гэж санана. Яг үүнтэй адилхан угсаатны онцлог бүхий хувцас, дуу хууртай байх, түүнийг эдэлж хэрэглээд дуугаа дуулаад аж төрөх чинь эрхэм дээд жаргал шүү дээ. Бидний хувьд

¹ М.Б, Дашбалбар суманд тэмдэглэн авав. 2022.10.25

Буриад угсаатны бүлгийн зан заншил гэдэг бол юманд хандах хандлага, хэрхэн аж төрөх тухай ойлголт шүү дээ. Хүнийг хүндлэх, мэндлэх уламжлалт ёс гэх мэт. Энэ бүхнийг “Алтаргана” наадам соёлын хувьд аргамжиж байна...²”

Алтаргана наадам буриадын соёл, уламжлалыг түгээн дэлгэрүүлэх, хадгалах хамгаалахад ихээхэн ач холбогдол өндөртэй байна. Дээрх наадмын талаарх Дашбалбар, Баяндун, Баян-уул, Цагаан-овоо зэрэг сумын иргэдийн ярж буйгаар ерөөсөө буриадын соёлын үндсэн цөм, түүнийг идэвхжүүлэх иргэдийн хувь ухамсар нэгдүгээрт чухал байр суурьтай байна. Харин иргэдийн ухамсрыг идэвхжүүлэхэд “Алтаргана” наадам асар их хувь нэмэр оруулж байна. Ёстой л соёлын аргамж нь болж байна.

“Хатиган” наадам: Дорнод аймгийн Матад сумаас гаралтай “Хатиган” овгийн наадам идэвх оролцоотой оролцдог аж. Хатиган түмний анхдугаар наадмыг 2009 онд 09-р сарын 09-ны өдөр 09 цагт Дорнод аймгийн Матад суманд зохион байгуулагдаж байжээ. Уг наадмыг соёлын гавьяат зүтгэлтэн, доктор, профессор Хатиган овогт Готовын Аким, Яруу найрагч С.Амартайван, УИХ-ын гишүүн асан, гавьяат барилгачин Р.Буд нарын санаачилгаар зохион байгуулагдсан байна. Уг наадмын зорилго нь мартагдсан зан үйл, соёлоо сэргээх, нийтийн соёл боловсрол дэмжих, түгээн дэлгэрүүлэхэд оршдог аж. Уг наадмаар Хатиган түмний их шүтээн их хар сүлдийг цэнгүүлж, тахилга үйлддэг байна. Улмаар 2012 онд Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан суманд Хатиганы хоёрдугаар наадам болж, Егүзэр хутагтын музей, Хатиганы их хар сүлдний тахилгыг сэргээж байсан байна. Харин 2015 онд Сүхбаатар аймгийн Сүхбаатар суманд, 2018 онд Дорнод аймгийн Матад суманд, 2021 онд Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан суманд зохион байгуулагджээ. Энэ удаа Эрдэнэцагаан сумынхан таван түмэн адууны баярыг хамтатган тэмдэглэсэн байна.

“Алтан дөрөө” наадам: Дорнод аймгийн Сэргэлэн, Баянтүмэн, Булган, Хэрлэн сумынхан үзэмчин угсаатны соёлын их наадам болгон Алтан дөрөө наадмыг 2005 оноос 3 жил тутамд нэг удаа зохион байгуулж байна. Уг наадам нь мөн олон улсын шинжтэй бөгөөд Монгол улсын Үзэмчин нараас гадна БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Үзэмчин нар уг наадам

² С.Б, Цагаан-овоо суманд тэмдэглэн авав. 2022.10.31

оролцдогоороо ихээхэн онцлогтой. Уг наадмын тухай Баянтүмэн сумын иргэн Ж.Б ийнхүү ярив.

“...өвгөд хэлэхдээ Үзэмчин түмэн олон зууны тэртээгээс монгол төрөө дээдэлж, их эзэн Чингис хааныхаа эмээлийн дөрөөг Сүлд шүтээнээ болгон тахиж жил бүр хошуу хотлоороо цуглаж өргөл хүндэтгэл үзүүлж, агт морь сэтэрлэж эрийн гурван наадам хийж байсан эртний уламжлалтай. Энэ уламжлалын дагуу алтан дөрөө наадмыг зохион байгуулж ирсэн түүхтэй. Уг наадмаар дуу хуур, урлагийн наадам, бөхийн барилдаан, хурдан болон жороо морины уралдаан, үзэмчин сурын харваа, үзэмчний уламжлалт бөмбөг шагайн наадаан, үзэмчин хувцасны үзэсгэлэн, хос морьтон шалгаруулдаг уламжлалтай...”³ хэмээн ярив.

Ийнхүү үзэмчин түмний өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, залуу хойч үедээ өвлүүлэн үлдээх зорилготой Үзэмчин ардын соёл, урлаг, спортын “Алтан дөрөө” наадам 2022 онд Дорнод аймгийн Чойбалсан хотод 7-р сарын 30-31 өдрүүдэд зохион байгуулагдсан байна.

“Баргажин” наадам: Барга түмний уламжлалт урлаг, өв соёл, спортыг түгээн дэлгэрүүлэх, залуу хойч үедээ өвлүүлэхэд зорилго бүхий уг наадам нь 2007 онд Дорнод аймгийн Хөлөнбуйр суманд анх зохион байгуулагдаж байв. Уг наадмын тухай Хөлөнбуйр сумын иргэн Г.А ийнхүү хуучлав.

“...уг наадам нь 2007 онд Хөлөнбуйр суманд, 2011 онд Гурванзагал суманд, 2015 онд ОХУ-ын БН Буриад улсын Хурамхан аймагт, 2018 онд Чойбалсан хотод, 2022 онд Хөлөнбуйр суманд зохион байгуулагдаж байна. Өдрөөс өдөрт хэл аялаг, өв соёлоо алдаж буй залуучуудын хувьд уг наадам нь нэг нэгнээсээ угсаатны онцлог бүхий өв соёлоо суралцах, хувцсаараа гоёх, танин мэдэх, дуу хөгжмөө суралцах гэх мэт олон талын ач холбогдолтой. Барга дээлтэй хүн маш ховор байлаа 10 гаруй жилийн дотор барга дээлтэй хүмүүс олон боллоо. Энэ бол тус наадмын нэг л амжилт юм. Цаашилбал олон ач холбогдолтой зүйлс байна. 2022 онд болсон уг наадмаар эрдэм шинжилгээний хурал, ардын дууны уралдаан, язгуур урлаг (үлгэр, тууль, магтаал, хурдан морины марзай, бөхийн цол)-ийн уралдаан, барга



³ Ж.Б, Дорнод аймгийн Баянтүмэн сум, 2022.11.03-нд тэмдэглэн авав.

угсаатны дээлийн загварын үзэсгэлэн, барга тоглоом наадгай, барга толиот бөхийн барилдаан, “Түнх” харваа, шагайн харвааны тэмцээн зэрэг онцлог үйл явдлууд болов...⁴”


Энэ хэсэгт бид угсаатны бүлэгт суурилсан соёлын наадмууд соёлын биет бус өвийн хадгалалт хамгаалалтад ихээхэн эерэг нөлөөтэй байгааг энд онцолж байна. Эдгээр наадам нь соёлын биет бус өвийн “соёлын аргамж” болж байна.

2.2 Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын нийгмийн асуудал



Нийт судалгаанд хамрагдсан 78 өвлөн уламжлагчид хүйсийн хувьд 55.4 хувь эрэгтэй, 44.6 хувь нь эмэгтэй байв (зураг:03).



⁴ Г.А, Дорнод аймгийн Хөлөнбуйр суманд тэмдэглэн авав.




Судалгаанд хамрагдсан нийт өвлөн уламжлагчдын 47.3 хувь нь 60-80 настай, 28.4 хувь нь 46-60 настай, 12.9 хувь нь 36-45 настай байгаа нь өвлөн уламжлагчдын ихэнх нь 75 орчим хувь нь 46-аас дээш насныхан байгаа нь (зураг:04) өвлөн уламжлагчид насны хувь дундаас дээш үеийнхэн байгаа мэт боловч бид ихэвчлэн өндөр настай хүмүүстэй уулзаж явсан тул бүх өвлөн уламжлагчдыг төлөөлөх боломжгүй гэдгийг энд дурдах ёстой.



Судалгаанд хамрагдсан 78 өвлөн уламжлагчдын 69 хувь 88.5 хувь нь Дорнод аймгийн уугуул иргэд бөгөөд бусад аймгаас шилжин ирсэн өвлөн уламжлагч 9 буюу 11.5 хувь нь байна (зураг:05). Харин сумын дундын


шилжилтийн хувьд харьцангуй бага буюу нийт судалгаанд хамрагдсан 78 өвлөн уламжлагчдын 20.5 хувь нь аль нэг сумаас шилжин суурьшсан өвлөн уламжлагчид байв (зураг:06).



Шилжин суурьшсан ирсэн өвлөн уламжлагчдын аанаас ирсэн тухай мэдээллийг дор зурагт өгүүлэв (зураг:07). Эндээс бид Дорнод аймгийн өвлөн уламжлагчдын сум дундын шилжилт хөдөлгөөн харьцангуй тогтвортой болохыг харж болохоор байна. Шилжилт хөдөлгөөн нь соёлын тархалтыг илэрхийлэх нэг үзүүлэлт болно хэмээн бид үзэж байна. Судалгааны явцад Дорнод аймгийн Халх гол, Чулуунхороот зэрэг сумд нь Социализмын үед сангийн аж ахуй ажиллах хүчин татах зорилгоор Монгол улсын өнцөг болон бүрээс ирсэн иргэд аж төрж амьдарч байна. Ялалт сангийн аж ахуй 18 аймгийн боловсон хүчнээс бүрдэж байжээ. Улмаар уг сангийн аж ахуйд тулгуурлан Халх гол сумыг байгуулсан бөгөөд эдүгээ 21 аймгийн иргэд аж төрж байна. Энэ утгаараа илгээлтээр ирсэн албан хаагчид дундын соёлыг үүсгэж, харилцан бие биеэсээ суралцах, нэг нэгэндээ нөлөөлсөн зүйлс цөөнгүй байгаа нь судалгааны явцад ажиглагдаж байв.


Тэдгээр шилжин ирсэн 17 хүний ихэнх нь сангийн аж ахуй байгуулах үед илгээлтээр ирсэн байх бөгөөд 20 дээш жил уг нутагтаа аж төрж амьдарч байна (зураг:08). Шинээр шилжин ирсэн өвлөн уламжлагчид харьцангуй цөөхөн байна. Шилжин ирсэн шалтгааны тухайд 37 хувь илгээлтээр тус бүс нутагт ирж суурьшсан бол 37 хувь нь гэрлэлтээр шилжин суурьшсан байна. Эдгээ өвлөн уламжлагчид үндсэн гурван хэлбэрээр соёлын өв өвлөн уламжлагч хэмээн бүртгэгдсэн байна. Үүнд, нэгт, орон нутгийн соёлын өвийн мэргэжилтний таньж

тогтоосноор, хоёрт, судлаачдын таньж тогтоосноор, гуравт, өөрийн хүсэлтээр гэсэн үндсэн гурван хэлбэрээр бүртгэгдсэн байна.




Өвлөн уламлагчдын нийгмийн асуудлыг тодруулахад тэдний боловсролын асуудал танин мэдэх нь ихээхэн чухал байна. Боловсролын асуудал нь эрүүл мэнд, өрхийн орлогын үндэс суурь үзүүлэлт болж байдаг.

Судалгаанд хамрагдсан 78 өвлөн уламжлагчдын 21 буюу 27 хувь нь дээд боловсролтой, 13 буюу 17.6 хувь нь тусгай мэргэжилтэй бол 44 хувь нь бүрэн дунд буюу түүнээс бага боловсролтой гэсэн статистик дүн гарч байна (зураг:11). Харин хөдөлмөр эрхлэлтийн хувьд 15 хувь тэтгэврийн насных бол 23 хувь нь төрийн байгууллагат, 21 хувь малчин үлдсэн 5 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг.




Амьжиргааны эх үүсвэрийн хувьд судалгаанд оролцсон 78 өвлөн уламжлагчдын 50 гаруй хувь нь тэтгэвэр тэтгэмжийн орлогоор, 28,2 хувь нь малын ашиг шимээс, 19 хувь нь цалингаас, 3-4 хувь нь өвийн ашиг шимээр орлого олдог хэмээн хариулжээ (зураг:14). Энд тэтгэвэр авдаг боловч малын ашиг шимийг мөн хүртдэг өвлөн уламжлагч нар цөөнгүй байсныг дурдах ёстой. Ер нь орон нутгийн иргэдийн хувьд малын ашиг шим ямар нэг хэмжээгээр өрхийн орлогын тодорхой хувийг эзэлж байдаг нь судалгааны явцад ажиглагдаж байв.

Зураг:14, өвлөн уламжлагчдын орлогын эх үүсвэр




Бид эндээс өвлөн уламжлагчдын эрүүл мэндийн асуудлыг сонирхон авч үзсэн юм. Өвлөн уламжлагчдын эрүүл мэнд, амьдралын хэвшлийг асуумж, ярилцлагаар тодруулж, амьдралын чанарын нөхцөл байдал дүн шинжилгээ хийхийг оролдов. Өвлөн уламжлагчид 57 хувь нь өөрсдийнхөө эрүүл мэндэд анхаарч чаддаг хэмээн хариулж байв (Зураг:15). Тэд уламжлалт идээ, ундаагаа улирлын онцлог, биеийн онцлогт тохируулан хүртэх, байнгын эрчимт хөдөлгөөнтэй амьдарч байна. Хамгийн чухал тэд зуны улиралд цагаан идээ, малын махыг зохисыг тааруулан хүртэх, уламжлалт эмийн ургамал, байгалийн жимс, жимсгэнэ зэргийг хүнсэнд өргөн хэрэглэж байна.



Зураг:15, эрүүл мэнддээ анхаарч чаддаг эсэх тухай


Харин эрүүл мэндийн үзлэг үйлчилгээг ихэвчлэн урьдчилан сэргийлэх зорилгоор авдаг тухай ярьж байв (Зураг:16).




Зураг:16, өвлөн уламжлагчдын эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлсэн шалтгаан

Бидний судалгаанд хамрагдсан өвлөн уламжлагчдын аман мэдээнээс үзэхэд амьдралынхаа хэвшил дунд эрүүл амьдралын хэв маягийг дадал болгохыг илүүд үзэж байсан бөгөөд рашаан сувилал жилд нэг удаа амарч сувилуулах хүсэл сонирхол өндөр байдаг тухай ярьж байв. Гэвч амьдралын боломж бололцоо, цаг зав харьцангуй бага байдаг нь нэг бэрхшээл болдог ажээ. Харин жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд нийт судалгаанд


хамрагдсан өвлөн уламжлагчдын 50-аас илүү хувь хамрагддаг байна. Ер нь эрүүл мэндийн үйлчилгээ авахад тэтгэврийн насныханд илүү боломжтой байдаг ажээ. Өвлөн уламжлагчдын амьдралын хэв маягтаа баримталж буй зарчим нь Их Юань улсын ордны идээ ундаа эрхэлсэн түшмэл, Хүсэхүй бээр эрхлэн бичсэн “Идээ ундааны Жинхэнэ Товч” хэмээн сурвалж бичигт буй “*жаргал цэнгэлийн ёс бол бие сайтар арчлах явдал юм. Бие арчлах ёс нь амьдралын алтан дундаж хэвийг сахихад оршино* (Урнаа.О 2021, 71)” хэмээн үзэл баримтлалтай дүйж байна. Мөн “*хавар, зун, намар, өвөл гэсэн дөрвөн улирлын арга билгийн ээлжлэн солигдох явцад үл зохицолдсоноос өвчин үүсдэг* (Урнаа.О 2021, 72)” хэмээн үзэж, улирлын онцлогтой идээ, ундаа хүртэж, хувцас, ажил хөдөлмөрөө зохицуулахыг илүүд үздэг ажээ. Тэд “*биеэ сайтар арчилж үл чадвал хэчнээн эм уусан ч үр дүнд хүрэхгүй* (Урнаа.О 2021, 73)” гэх үзэл баримтлалыг өвлөн уламжлагчид баримталж байна. Хамгийн чухал нь тэд “*мянган өдрөөр эм уух нь ганц биеэр нэгэн шөнө мансууртал нойрсоход үл хүрнэ* (Урнаа.О 2021, 73)” хэмээн үздэг аж. Иймд нийт өвлөн уламжлагчдын 50 гаруй хувь нь нэг удаа үзлэг шинжилгээнд хамрагддаг байна (Зураг:17)




Судалгаанд хамрагдсан нийт өвлөн уламжлагчдын 41 хувь нь нэг удаа эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэхдээ 50,000 хүртэлх мянган төгрөгөөр үзлэг оношилгоонд хамрагддаг байна. Харин 28.8 хувь нь 50,000-150,000 төгрөг нэг удаа эрүүл мэндийн үйлчилгээ авахдаа зарцуулдаг байна. Иймд, өвлөн уламжлагчдын эрүүл амьдрах дадал хэвшилд тодорхой хэмжээнд анхаарал хандуулж үзлэг, шинжилгээнд хамруулах үйлчилгээг эрчимжүүлэх шаардлага байна. Мөн өвлөн уламжлагчдын ихэнх нь эм тариагаас илүүтэй сувилал, рашаан, уламжлалт анагаах ухааны эмийн бус эмчилгээ, сувиллыг илүүд үзэж байна.



Бидний судалгаанд хамрагдсан өвлөн уламжлагчдад хамгийн нас ахихын хирээр хараа муудах асуудал бий болж байгаа тухай ярьж байв (зураг:19)



Харин нийгмийн амьдралд оролцоход ямар нэг тусгай хэрэгцээт тохируулаг шаардагдах өвлөн уламжлагч судалгаанд хамрагдаагүй (зураг:20). Энэ Дорнод аймгийн хэмжээнд нийгмийн амьдралд оролцоход тусгай хэрэгцээт тохируулаг шаардагдах өвлөн уламжлагч байхгүй гэсэн үг биш болохыг анхаарах хэрэгтэй.



Судалгаанд оролцсон өвлөн уламжлагчдын гурав нь нийгмийн амьдралд оролцоход ямар нэг тусгай хэрэгцээт үйлчилгээ шаардлагатай хэмээн хариулж байсан. тэдгээр гурван өвлөн уламжлагч нь гурвуулаа нас өндөр болсны улмаас нүдний хараа тодорхой хэмжээнд муудсан тухай ярьж байв.




Бид энэ хэсэгт өвлөн уламжлагчдын нийгмийн асуудлыг товч авч үзлээ.

Дорнод


аймгийн СББӨ түүнийг өвлөн уламжлагчдын хувьд орлогын эх үүсвэр нь тэтгэврийн орлого, цалин, малын ашиг шим болох тухай үр дүнд судалгааны асуумжаар гарч ирэв. Тухайн өвлөн уламжлагчийн эзэмшиж буй мэдлэг эдийн засгийн хувьд амьдралд тодорхой хэмжээнд дэм болж чаддаггүй байна (зураг:22).

Иймд, соёлын өвийг өрхийн санхүү, орлоготой уялдуулах хэрэгцээ шаардлага байна. Тухайлбал, зарим суманд соёлын өвөөс олох орлого харьцангуй бага, мөн эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй тул тухайн эрдэм мэдлэгт тулгуурласан үйл ажиллагааг эрхлэхгүй байна. Энэ мэт жишээ цөөнгүй байв. Иймд, өвийн онцлогт нийцсэн бодлого боловсруулах аймаг, сумын түвшинд анхаарал хандуулах шаардлага байна.



2.3. Соёлын биет бус өвийн оршин тогтнох чадварыг тодорхойлох судалгаа

Соёлын биет бус өвлөн уламжлагчийг таньж тогтоох, тэднийг бүртгэлд оруулах ажил Монгол улсын хэмжээнд тодорхой ахиц дэвшилтэй байсаар байна. Бидний судалгаанд хамрагдсан өвлөн уламжлагчдын ихэнх нь буюу 57 хувь нь орон нутгийн соёлын өвийн ажилтны таньж тогтоосноор тус бүртгэлд хамрагджээ. Гэхдээ энд бодох ёстой хэд хэдэн асуудал байна. Үүнд, Дорнод аймгийн 14 сумын соёлын өвийн ажилтнуудын 90 орчим хувь мэргэжлийн бус хүмүүс ажиллаж байна. Иймд, сум орон нутгийн соёлын өвийн ажилтнуудыг мэргэшүүлэх, ажиллах нөхцөл, боломжоор хангах, дэмжлэг үзүүлэх хэрэгцээ шаардлага байна.



Зураг:23, соёлын өвийн бүртгэлд хэрхэн бүртгэгдсэн байдал

Ихэнх өвлөн уламжлагчид өвөө өөрийн гэр бүлийн гишүүдээс өвлөн авдаг болох нь тус судалгааны үр дүнгээс ажиглагдаж байна. Гэхдээ тухайн өвийн онцлогийг харгалзан үзэж шаардлага байна (Зураг: 23). Тухайлбал, эмийн ургамлаар хүн анагаах, бариа засал зэрэг угсаатны анагаах ухааны эрдэм мэдлэгийг шууд угсааны хүн гэхээсээ гартаа мэдрэмжтэй, зохих шалгуурыг хангасан хүнд зааж сургадаг байх жишээтэй. Дорнод аймгийн Дашбалбар сумын өвлөн уламжлагч, бариач шарайд омгийн Лосолын Мядагмаа бариачийн эрдмийг өвлөн уламжлуулах тухайд ийнхүү ярив.


“...Хэн дуртай нь хүний яс барих эрдмийг сурах бололцоогүй. Гартаа мэдрэмжтэй хүн энэ эрдмийг сурах боломжтой. Барих арга барилыг сурахаар ирсэн хүний гарын мэдрэмжийг шалгаж үзнэ. Ер нь бариач болох хүн гартаа мэдрэмжтэй төрдөг. Тэр мэдрэмжийг би гарын барьж үзээд мэдэж чадна. Бодитоор бол эхний ээлжид гүзээтэй усанд хэдэн модны мөчир хугалж хийгээд эвлүүлэлддэг. Суурь увдис байх ёстой л доо. Энэ сорилтыг давсны дараа хүний бариулж оношлуулж үзнэ. Ерөнхий зүйлийг мэдэж байх ёстой. Мэдэж байвал дараа дараагийн зүйлийг зааж өгнө өө...”



Зураг: 24, Соёлын биет бус өвийн авьяасаа өвлөн авсан байдал


Энэ бүхнээс үзэхэд өвийн онцлогоос хамаараад өвлөн уламжлуулах арга хэлбэр харилцан адилгүй байна аа. Нийт судалгаанд хамрагдсан өвлөн уламжлагчдын 46 орчим хувь нь нэгдэх үеийн өвлөн уламжлагчид байгаа нь өвлөн уламжлагчид харьцангуй залуужиж байгаа нь харагдаж байна (Зураг:24). Гэхдээ тухайлбал өвийн онцлогийг мөн л бодолцох ёстой. Яаралтай хамгаалах шаардлагатай болон төлөөллийн төрөлд хамаарах өв тус бүрийн өвлөн уламжлагчид нь хоёр буюу түүнээс дээш үеийн өвлөн уламжлагчид байгаа бол сур харваа, уртын дуу, суран эдлэл, модон эдлэл, бөх морины цол дуудах гэх мэт өвийн өвлөн уламжлагчид нь нэгдүгээр үеийн өвлөн уламжлагчид байх нь түгээмэл байгаа ажиглагдаж байв. Ер бид цаашдаа өв тус бүрийн тухайлан нарийвчлан судлах, өвлөн уламжлагчдын өнөөгийн байдлыг тодорхойлох, тухайн хүн эзэмшин буй өвөө хэрхэн уламжлуулж буй үйл явцад дүн шинжилгээ хийх шаардлага байна. Судалгаанд хамрагдсан өвлөн

уламжлагчдын 71,8 хувь эзэмшиж буй өвөө тодорхой хэмжээнд өвлөн уламжлуулж байгаа бол 28,8 хувь нь яар нэг хэмжээгээр өвлүүлж уламжлуулж амжаагүй байгаа үр дүн гарсан. Эдгээр 28,2 хувь бол төлөөллийн болон яаралтай хамгаалах соёлын биет бус өвийн төрөлд хамаарах өвүүд байгааг энд онцлон тэмдэглэх байна. Соёлын биет бус өв нь нийгмийн амьдрал дээр ахуй хамаатан садан, нутгийнхандаа өвлүүлэх байдал түгээмэл байна (зураг:25).




Зураг: 25, хэд дэх үеийн өвлөн уламжлагч болох тухай

Харин соёлын биет бус өвөө өвлөн уламжлуулах арга барил харьцангуй уламжлалаа хадгалж байгаа тухай судалгааны үр дүн гарсан. Уламжлалт гэдэг нь хэрхэн сурсан тэр аргаараа дараагийнхаа хүмүүс зааж сургаж байгаа хээрийн судалгааны явцад ажиглагдаж байв.




Зураг: 26, ямар хэлбэрээр өвлүүлдэг тухай (56 хүн хариулсан)

Харин тодорхой хэмжээнд өөрчлөгдөж буй арга барилд хамаарах өвүүд нь өрхийн үйлдвэрлэл рүү чиглэсэн сур суран эдлэл, модон эдлэл, цагаан идээ боловсруулах арга ажиллагаа нийгмийн өөрчлөлт, технологийн дэвшил зэргийн улмаар бага зэрэг өөрчлөгдсөн зүйлс ажиглагдаж байв (Зураг:27).



Зураг: 27, СББӨ үйлдэх арга нь өөрчлөгдсөн эсэх

СББӨ-ийг сум орон нутгийн түвшинд дэмжлэг харьцангуй сул байдаг аж (зураг:28). Энэ хууль эрх зүйн орчин бүрдээгүйтэй холбоотой болов уу.




Зураг:28, өвлөн уламжлуулах арга ажиллагаа юун болж өөрчлөгдсөн тухай

Сүүлийн жилүүдэд сумын баяр наадмаар морь, бөхийн цол дуудсан авьяастан нар урамшуулал олгодог болсон гэнэ.

Хувийн хэвшлийн дэмжлэгтэйгээр СББӨ-ийг дэмжиж, уралдаан тэмцээн сүүлийн жилүүдэд эрчимжих болсныг өвлөн уламжлагчид онцолж байв. иймд, төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд СББӨ өвлөн уламжлагчдыг дэмжих, алдаршуулах, нийгэм үнэ цэнийг нь нэмэгдүүлэх чиглэлийн ажлыг эрчимжүүлэх хэрэгцээ шаардлага байгааг онцолж байв. Энэ жил МУ-ын хэмжээнд зохион байгуулагдсан “Нүүдэлчин монгол” соёлын их наадмыг ихээхэн ач холбогдол өндөртэй үйл ажиллагаа боллоо хэмээн талархаж байна. энэ мэт соёлын наадмыг тогтмол зохион байгуулах нь цаашид ихээхэн үр өгөөжтэй хэмээн үзэж байна. Өвийг цаашид тогтвортой үйлдэхэд төсөл, санхүүгийн дэмжлэг, байр тэнхим, материал хэрэглэгдэхүүний дэмжлэг шаардлагатай байгаа тухай тоо судалгааны үр дүн гарсан байна (зураг:29)

2.6. Харьяа засаг захиргааны нэгжээс танд дэмжлэг үзүүлдэг үү? Хариултаа сонгоно уу?


78 responses



Зураг:29, засаг захиргааны нэгжээс дэмждэг эсэх тухай


2.4. Соёлын биет бус өвд эерэг болон сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийн судалгаа

Соёлын өвийн хадгалалт хамгаалалтын асуудал байгалийн ашиг шимийн хүртээмж ихээхэн чухал ач холбогдолтой байна (зураг:30). Монголчуудын соёлын өвийн онцлогийг мал аж ахуйн соёл, бэлчээр, ус байгалиас ангид авч үзэх бололцоогүй. Ийм ч ураас тухайлсан соёлын өвүүд байгаль нягт уялдаа холбоотой аж.



Зураг:30, өвийг тогтвортой үйлдэхэд шаардлагатай дэмжлэгийн тухайд


Соёлын биет бус өвд сөргөөр нөлөөлж болох магадлалтай нэг зүйл нь бэлчээрийн даацын доройтол, ой хээрийн түймэр хэмээн үзэж байна (зураг:31).




Зураг:31, СББӨ-д үзүүлэх байгалийн эерэг нөлөөлөл

Өнөөдрийн хувьд Дорнод аймаг төдийлөн бэлчээрийн доройтолд өртөөд буй аймаг бол биш гэвч хэрэв СББӨ-д байгалийн сөрөг нөлөөлөл байдаг гэж үзвэл бэлчээрийн доройтлын асуудал байж болох юм. Монгол улсын аль ч хэсэгт бэлчээр доройтох нь тухайн бүс нутгаас иргэд шилжин суурьших, отор нүүдэл хийх томоохон шилжилт хөдөлгөөнийг бий болгодог. Энэ нэг талаар соёлын өвд ихээхэн нөлөө үзүүлж болох юм гэдэг талаас хариулж байсныг энд онцлон дурдах байна.


Цахим хэлбэрээр олон нийтэд соёлын өвийн талаарх мэдээллийн хүргэх, сурталчлах ажил соёлын биет бус өвд эерэг нөлөөлж буй байна (зураг:32) хэмээн үзэж байсан бол соёлын өвийн талаарх мэдлэг мэдээллийн дутмаг байдал соёлын өвийн үнэ цэнэ, өвлөн уламжлагчийг үнэлэх нийгмийн үнэлэмж бага байгаа нь соёлын биет бус өвд сөргөөр нөлөөлж байна (зураг:33). Иймд, соёлын биет бус өвийн үнэлэмжийн асуудалд анхаарлаа хандуулах, эрчимжүүлэх шаардлагатай байна хэмээн үзэж байв.



Зураг:32, СББӨ-д үзүүлэх байгалийн сөрөг нөлөөлөл



Зураг:33, СББӨ-д үзүүлж буй нийгмийн эерэг нөлөөлөл





Зураг:34, СББӨ-д үзүүлж буй нийгмийн сөрөг нөлөөлөл

Дорнод аймгийн хувьд нийтэд нь ямар нэг соёлын өвөөр илэрхийлэх боломжгүй байна. Учир нь, өвлөн уламжлагчид болон нутгийн иргэд мэдэхгүй хэмээн хариулж байв. Энэ хариулт бол бодит байдал. Дорнод аймгийн соёлын орон зай Халх, Буриад, Үзэмчин, Барга угсаатны бүлэг, дээр нь МУ-ын 21 аймгийн төлөөлөл байхад ямар соёлын өвөөр энэ аймгийн тодорхойлж болох вэ? Энэ бол боломжгүй ойлголт юм. Энийг асууж байгаа нь бусад өвийг үгүйсгэж нэгийг онцгойлох гэсэн алдаа хэмээн үзлээ. Учир ЮНЕСКО-ийн соёлын өвийн конвенц соёлын ялгаатай байдал, өвөрмөц төрөл зүйлийг хүндэтгэн хэмээн үзсэн байдаг. Харин эндээс бид ганцхан ижилсэл харагдаж байгаа нь “Монгол” гэх үндэсний ижилсэл юм. Бүх хүн санал нэгтэйгээр Монгол үндэстний өв соёл бол бүрдэл хэсэг болж буйдаа, түүнийг бүтээж буйгаараа бахархаж байв. Өөрөөр хэлбэл, том орон зайн хувьд Дорнод аймаг бол Монгол хэмээх соёлын аргамжны нэг бүрдэл хэсэг юм.

2.5. Соёлын биет өв өвлөн уламжлагчдын ургийн бичиг хөтлөлтийн асуудал


Монголчуудын язгууртан нарын гэр бүлийн гишүүнчлэлийн нэгэн том соёл нь овгийн ургийн бичиг хөтлөлт юм. Харин Монгол улсын төрөөс цус ойртолтоос хамгаалах үйл явцтай холбон бүх нийтийг угийн бичигтэй болгох өрнүүлж, нийтийн шинэ соёл бүтээх, бий болгох үйл явц монгол улсад өрнөж буйг энэхүү судалгааны үр дүн нотлон харуулж байна (зураг:35). Мөн угийн бичиг бол тухайн гэр бүлийн хувийн нууц хадгалагдаж байдаг тул зарим хүн хөтөлдөг эсэхээ хэлэхгүй байхыг үгүйсгэхгүй юм. Гэхдээ судалгаанд хамрагдсан 78 өвлөн уламжлагчдын 60 гаруй хувь нь ямар нэг байдлаар угийн бичиг хөтөлдөггүй аж.






Угийн бичиг хөтлөх зөв, буруу эсэхийг өвлөн уламжлагчид төдийлөн ач холбогдол өгөхгүй байв. Угийн бичиг хөтлөх заавар гэсэн номыг баримтлан сумын захиргаанаас угийн бичиг хөтлөхийг шаарддаг ч ард иргэд төдийлөн ач холбогдол өгөхгүй байна. нөгөө талаараа уг удмаараа амаас ам дамжуулан уламжлуулж буй үйл явц харин хүчтэй байна. Дорнод аймгийн хүүхэд багачууд өвөө эмээгийнхээ тухай, өвөө эмээгийнх нь ах дүү нар тэдний хүүхдүүдийг маш сайн мэдэж байна. ураг удмын талаар аман уламжлал монголчуудын дунд хүчтэй байгаа нь харагдаж байв.

Судалгааны үр дүнгээс харахад угийн бичиг хөтөлж буй өвлөн уламжлагчдын хөтөлж буй үе нь 3-4 үе дээр явж байгаа (зураг: 37) нь шинээр хөтөлж эхэлсний илэрхийлэл юм.



Зураг:37, хөтөлж буй угийн бичиг нь хэд дэх үе дээрээ явж буй тухай


Хөтлөх хэлбэр нь шугаман (зураг:38) буюу Монгол улсын төрөөс орон нутгийн засаг захиргааны байгууллагуудад хүргэсэн үлгэрчилсэн заавар, арга зүйтэй нийцэж байгаа нь Монгол улсын төрөөс эмхлэн буй болгож буй нэгэн нийтийн соёл бол ургийн бичиг хөтлөх үйл явц болж байна. Угийн бичиг хөтлөх зааврыг сургалт, багийн дарга нараас сурч авсан хэмээн хариулж байв.



2.6, Дүгнэлт: Соёлын биет бус өвийн өнөөгийн байдал ба соёлын бие бус өвийн өвлөн уламжлагчдын оршихуй

Монгол улсын төрөөс Соёл урлагийн дэмжих, хөгжүүлэх, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжихэд чиглэсэн олон үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаагийн нэг нь СББӨ-ийн үзлэг, судалгааны ажил юм. Бид Дорнод аймгийн 14 сумын соёлын төвийн үйл ажиллагаатай танилцаж, 110 гаруй соёлын биет бус өв өвлөн уламжлагчидтай уулзаж, ярилцлага, судалгаа хийлээ. Судалгааны нэг зорилго нь өвлөн уламжлагчдын өнөөгийн байдалтай танилцах байв. Тэд өвлөн буй соёлын өвөө нийгмийн эрэлт хэрэгцээ өндөртэй хэмээн үзэж байна(зураг:39). Гэвч Монгол улсын соёл, түүний өвлөн тээж яваа “хөх өвгөд”, “эмгэд” минь хорвоогийн жамыг даган өдрөөс өдөрт цөөрсөөр байна. Чухамхүү бид хир хэмжээтэйг баримтжуулан авсныг тооцох боломжгүй ч чамлахааргүй арвин сан хөмрөг бүрдүүлсэн хэмээн итгэж байна. Гол асуудал бол өвлөн уламжлагчдын оршихуй өнөөдөр ямар байна вэ гэдэг асуудал юм. Тухайн өвлөгчийн өвлөн уламжилж буй өв түүний аж ахуй, эрүүл мэндийн хэрэгцээ шаардлагад нэмэр болж чадахгүй байгаа явдал нэн хүнд асуудал болж байна. Тэдний өөрсдийнх нь үзэж буйгаар өвийн талаарх нийтийн мэдлэг, үнэ цэнэ, үнэлэмж доогуур байгаа явдал хамгийн сэтгэл чилээсэн асуудал

болж байна. Өнөөдөр өв соёлын ундраг, эх булаг болсон өвлөн уламжлагчаа анхаарал хандуулахгүй шаардлага байна. Тэдний оршихуй сайжирч гэмээр дагаад соёлын өвийн хөгжил, хадгалалт хамгаалалт сайжирна хэмээн таамаглаж байна.



Зураг: 39, Дорнод аймагт СББӨ-ийг эдийн засгийн эргэлтэд оруулах эрэлт байгаа эсэх

**ГУРАВДУГААР БҮЛЭГ: ДОРНОД АЙМАГТ ХИЙСЭН СОЁЛЫН
БИЕТ БУС ӨВИЙН ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮН**

3.1 Судалгааны дүн мэдээ


Соёл урлагийн газраас гаргасан Дорнод аймгийн сум тус бүрийн СББӨ-ийн бүртгэлд нийт 96 өвийн 337 өвлөн уламжлагч бүртгэгдсэн байна. Бидний үзлэг судалгаанд Монгол улсын яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэл байх 7 айн 83 өвөөс 4 айн 9 өв, Монгол улсын соёлын биет бус өвийн төлөөллийн үндэсний бүртгэл байх нийт 7 айн 279 өвөөс 7 айн 63 өв тус тус бүртгэгдлээ. Нийт 109 өвлөн уламжлагчид уулзаж, ярилцлага судалгаа авснаас 78 СББӨ-ийн өвлөн уламжлагчийг тоон судалгааны хамруулав.



Монгол улсын яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэл		
№	7 ай сав	Өвийн төрөл
1	Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд	Барга аман аялгуу -1
2	Ардын язгуур урлаг	-
3	Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага	Язгуур шүтлэгийн ёс, зан үйл Уул овоо тахих зан үйл - 2 Төл авхуулах ая дуудлага, зан үйл - 1 Буриад хуримын ёс, зан үйл - 1
4	Байгалийн болон сав шим ертөнцийн тухай мэдлэг, зан үйл	“Тэнгэр, эрхэс, цаг агаар шинжих уламжлалт мэдлэг-1
5	Уламжлалт арга ухаан	
6	Мал маллах арга ухаан	-
7	Уламжлалт гар урлал	
	Бүгд: 4	9



Монгол улсын соёлын биет бус өвийн төлөөллийн үндэсний бүртгэл		
№	7 АЙ САВ	ӨВИЙН ТӨРӨЛ
1	Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд	Буриад аман аялгуу -1
		Монгол уран бичлэг - 1
		Хууч яриа – 6
		Шог хошин яриа - 1



		Дом -1
		Цол дуудлага - 7
		Ерөөл - 1
		Магтаал - 1
		Бөө мөргөлийн холбогдолтой аман илэрхийлэл-1
		Үе удам, овог төрлийн нэршил, үг - 1
2	Ардын язгуур урлаг	Халх уртын дуу – 8
		Буриад-Барга уртын дуу 1
		Үзэмчин-Дариганга уртын дуу -1
		Барга богино дуу -1
		Үзэмчин богино дуу - 1
		Халх богино дуу – 1
		Бүүвэйн дуу - 1
		Харилцаа дуу - 1
		Монгол хөөмийн уламжлалт урлаг – 1
		Морин хуур хөгжмийн уламжлалт урлаг – 3
		Хуучир хөгжим тоглох урлаг – 1
		Цохилуур хөгжим тоглох урлаг – 1
		Хурдан морины хүүхдийн гийнгоо, марзай – 1
		Бөөгийн ая дан – 1
3	Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлагын өв	Хүүхэдтэй холбоотой ёс, зан үйл, найр - 1
		Монгол нүүдлийн зан үйл – 1
		Мал аж ахуйн холбогдолтой уриа дуудлага -1
		Хурдан морины уралдаан - 1
		Үндэсний сур харваа - 1
		Тааварт тоглоомын уламжлалт төрлүүд - 1
		Хөлөгт ба өрөгт тоглоомын уламжлалт төрлүүд - 1
		Цаасан болон модон тоглоомын уламжлалт төрлүүд - 1
		Шагайгаар тоглох, наадах
4	Байгалийн болон сав шим ертөнцийн тухай	Хурдан морь сойх, уралдуулах мэдлэг -1
		Чулуу татах мэргэ / “Ховлог” /- 1



	мэдлэг, зан үйл	
5	Уламжлалт арга ухаан	Цагаан идээ бэлтгэх уламжлалт арга – 1 Монгол үндэсний уламжлалт, цай ундаа хийх арга - 1 Арьс, шир боловсруулах уламжлалт арга – 2 Бариа заслын аргаар анагаах арга ухаан – 4 Ургамалын зүйлээр анагаах арга ухаан – 1 Дом, шившлэгийн аргаар анагаах арга ухаан - 1 Мал хатгах уламжлалт мэдлэг - 2 Угийн бичиг хөтлөх монгол уламжлалт мэдлэг - 1
6	Мал маллах арга ухаан	Хонин сүрэг маллах арга ухаан – 1
7	Уламжлалт гар урлал	Буриад хувцасны уламжлалт урлал - 1 Халх хувцасны уламжлалт урлал - 2 Бөөгийн хувцас урлал – 1 Эсгий ширмэл урлал – 1 Монголын уламжлалт модон эдлэлийн урлал – 3 Үйсэн урлал - 1 Үндэсний нум сум урлал -1 Монгол эмээл хийх урлал - 1 Монгол дархны уламжлалт арга ухаан - 3 Баримлын урлал -- 1 Шуумлын урлал - 1 Модон сийлбэрийн урлал - 1 Зээгт наамлын уламжлалт урлал – 1 Ходок тэрэг хийх уламжлалт арга - 1
	Бүгд: 7 ай	63 өв



Дд	Гэрэл зургийн нэр	Видео файлын нэр	Өвлөн уламжлагчийн мэдээлэл	Өвлөн уламжлагчийн гэрэл зураг
<p>Халхгол сум (DoHG)</p> <p>Халхгол суманд 2022 оны 10 дугаар сарын 15-17-нд ажиллав. Халхгол сумаас үзлэг, судалгаанд хамрагдсан өвийн төрлүүд. Үүнд: Хууч яриа, Хурдан морь сойх, уралдуулах мэдлэг, Монгол идээ ундаа, шар будаатай борцтой цай хийх арга ажиллагаа, Бүүвэйн дуу, Монгол гэрийн уламжлалт урлал, Тэмээ, хонины ноосоор утас ээрэх, Асуух нурууны үг, Халх хувцасны уламжлалт урлал, Монголын уламжлалт арьс ширэн эдлэлийн урлал, Бариа заслын аргаар анагаах арга ухаан өвийн төрлүүд үзлэг судалгаанд хамрагдлаа.</p> <p>Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд анхан шатны байдлаар бүртгэгдсэн өвлөн уламжлагчдын бүртгэлд тулгуурлан сумдын өвлөн уламжлагчдийг үзлэгт хамрууллаа. Халхгол сумаас үзлэгт хамрагдах 15 өвийн зүйл, 22 өвлөн уламжлагчийн бүртгэл гарсан. Шинээр бүртгэлд хамрагдсан 3, Үзлэг судалгаанд хамрагдаагүй 12 өвлөн уламжлагч байсан бөгөөд үүнээс нас барсан 3, нийт 10 өвлөн уламжлагчийг хээрийн үзлэг судалгаанд хамруулав.</p>				
1	2022.DoHG.Photto.Myagmarsuren.Part1	2022.DoHG.video.Myagmarsuren.Part1	<p>Нэр: Л.Мягмарсүрэн</p> <p>Ай сав: Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд</p> <p>Өвийн нэр: Хууч яриа</p> <p>Энэ нутагт То вангийн үед “Хөгийн найман багачууд” хэмээх дуучид хөгжимчид, цамын бүжигчийн хосолсон томоохон урлагийн тоглолт явагддаг байж. Энэ уламжлал мартагдаад байсныг бид дахин сэргээх, улмаар орон нутгийн түүх, соёлын чиглэлийн судалгааг эрчимжүүлэхээр ажиллаж байна.</p>	
	2022.DoHG.Photto.Myagmarsuren.Part2	2022.DoHG.video.Myagmarsuren.Part2		
		2022.DoHG.video.Myagmarsuren.Part3		



2	2022.DoGH.Photo.Orlomjav.part1	2022.DoGH.Video.Orlomjav.part1 2022.DoGH.Video.Orlomjav.part2	<p>Нэр: Н. Орломжав</p> <p>Ай сав: Байгалийн болон сав шим ертөнцийн тухай мэдлэг, зан үйл</p> <p>Өвийн төрөл: Хурдан морь сойх, уралдуулах мэдлэг.</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Хурдан морь сойх, уралдуулах мэдлэг эдэлгээнд сургах эрдэм мэдлэгийг өвлөн уламжлагч. Тэрээр эмэгтэй хүн морь сойж уралдуулж болно гэдгийг харуулах зорилгоор анх морь уяж эхэлсэн. Тэрээр уяач хүн морио мэдэрч чадах ёстой. Яг хүнтэй адилхан тэгж хэмээн морины уяа сойлог таарч, бие нь хөнгөрдөг. Надад морь уях арга ухааныг хэн ч зааж өгөөгүй. Тэр бүү хэл морины уяанаас холуур яв гэж хэлдэг байсан. Би өөрийн олон жилийн хичээл зүтгэл, ажиглалт, туршлагын үндсэн дээр морь уяж сурсан. Хүн ажиглаж, мэдэрч чадвал морь уях эрдэм бидний ахуй дотор бий.</p>	
3	2022.DoHG.Photo.Vadamjav.L.part1	2022.DoHG.Video.Vadamjav.L.part1 2022.DoHG.Video.Vadamjav.L.part2 2022.DoHG.Video.Vadamjav.L.part3 2022.DoHG.Video.Vadamjav.L.part4 2022.DoHG.Video.Vadamjav.L.part5 2022.DoHG.Video.Vadamjav.L.part6 2022.DoHG.Video.Vadamjav.L.part7	<p>Нэр: Л.Бадамжав</p> <p>Ай сав: Уламжлалт арга ухаан</p> <p>Өвийн нэр: Монгол үндэсний уламжлалт, цай ундаа хийх арга</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Тэрээр нутгийн онцлог бүхий шар будаа, борцтой хийцтэй цай чанах, түүнтэй холбоотой зан үйл, уламжлалт дэгийг өвлөн уламжилж буй ажээ. Тэрээр хэлэхдээ цай чанах нь нэг үйл юм. үүнд, цайны идээ, цайны идээ боох арьс зэрэг ордог. Энэ миний цай боодог арьс бол унаганы арьс бөгөөд намайг бэр болж ирэхэд хадам ээж минь өгч байсан юм. Цай буцлах үед сайхан самрах ёстой. Цай гэдэг сэтгэлийн илэрхийлэл болдог тул эхлээд тэнгэр байгальдаа өргөж, дараа нь бурхан тахилдаа дээж л тавина. түүний дараа гэрийн эзэндээ (нөхөр) аяглаж, хоёр гардан барих ёстой. Түүний дараа гэр буй зочдод хүйс, насны эрэмбээр цай барьдаг. Цай уух гэдэг чинь зүгээр цай уухын нэр биш шүү дээ. Ёс буюу дараалал хүндлэлийг чанад сахих ёстой гэж ээж минь хэлдэг байсан юм. Сайхан цай чанаад аяглаад барихад</p>	



			гэрт зочилсон хүн бүр баясаад гардаг гэдэг юм. Тэр хэмжээгээр ажил үйлс бүтэмжтэй, амьдрал тэгширдэг гэдэг юм билээ.	
4	2022.DoHG.Photo.Mandal.A.Part1	2022.DoHG.Video.Mandal.A.Part1	<p>Нэр: А.Мандал</p> <p>Ай сав: Ардын язгуур урлаг</p> <p>Өвийн нэр: Бүүвэйн дуу</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Тэрээр Хөвсгөл аймгийн уугуул хүн юм. Маанийн ая дээр бүүвэйн дуу аялдаг. Мантгар цагаан хүү бүүвэй бүүвэй</p> <p>Бөндгөр цагаан охин бүүвэй бүүвэй</p> <p>Дан дан даалуутай</p> <p>Далан гурван настай</p> <p>Хөөр хөөр дуутай</p> <p>Хөгнөг хоёр гурван үстэй</p> <p>бүүвэй бүүвэй бүүвэй бүүвэй</p> <p>Удмыг минь залгасан ухаан охин бүүвэй</p> <p>Ургийг минь өргөсөн ухаант хөвгүүд</p> <p>бүүвэй бүүвэй бүүвэй бүүвэй</p>	
5	2022.DoHG.Photo.Sharkhuu.Sh.Part1	2022.DoHG.Video.Sharkhuu.Sh.Part1	<p>Нэр: Ш. Шархүү</p> <p>Ай сав: Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд</p> <p>Өвийн нэр: Хууч яриа.</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Тэрээр Хөвсгөл аймгийн уугуул. Халхгол суманд илгээлтээр ирсэн. Нутаг орны ахмад хүмүүсээс сонссон шог хошин яриаг цуглуулдаг. Мөн гэрийн мод хийдэг байсан. Одоо нас өндөр болоод хийгүй байгаа аж.</p>	




6	2022.DoHG.Photo.Nyamsuren.T.Part1	2022.DoHG.Video.Nyamsuren.T.Part1	<p>Нэр: Т.Нямсүрэн</p> <p>Ай сав: Уламжлалт гар урлал</p> <p>Өвийн нэр: Монгол гэрийн уламжлалт урлал</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Тэрээр бургасан ханатай гэр урладаг. Бургасаа Халхын голоос авч, хатааж, гар аргаар матаж, тэмээний арьсаар үддэг. Нутгийнхаа Цэндийн Бямбаа гэж хөгшинд туслангаа 8-р ангид байхдаа өөрийн сонирхлоор сурсан. Бургасан хантай гэр эдэлгээ сайтай, хүний нэг насанд эвдрээд байдаггүй тул захиалга их ирдэг. Энэ өвийг сурья мэдье гэсэн хүн төдийлөн алга.</p>	
7	2022.DoHG.Photo.Hishigt.M.Part1	2022.DoHG.Video.Hishigt.M.Part1	<p>Нэр: М.Хишигт</p> <p>Ай сав: Уламжлалт арга ухаан</p> <p>Өвийн нэр: Ноос, ноолуур боловсруулах уламжлалт арга</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Ховд аймгийн Дөргөн сумаас гаралтай. Тэрээр хонь, тэмээний ноосыг боловсруулан утас ээрдэг. Утсаараа ширдэг ширэх, нэхмэл хийх гээд төрөл бүрээр ашигладаг. 1990-ээд оны хүнд жилүүдэд тэмээний ноосоор нэхсэн цамц, майк, өмд, оймс зэргээр хэсэг амьдарсан. Амьдралаа тэнхрүүлэхэд түүний ээж, эмээгээсээ сурсан эрдэм чухал нөлөө үзүүлсэн аж. Тэрээр Ховд аймгийн уугуул. Илгээлтээр энд ирж амьдарсан.</p>	



8	2022.DoHG.Photo.Ayush.Ch.Part1	2022.DoHG.Video.Ayush.Ch.Part1	<p>Нэр: Ч. Аюуш</p> <p>Ай сав: Уламжлалт гар урлал</p> <p>Өвийн нэр: Халх хувцасны уламжлалт урлал</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Тэрээр монгол дээл оёх аргыг багадаа ээжээсээ сурсан. Ажлын хажуугаар амьдралаа дээшлүүлэх гэж орой үдэш дээл оёж байлаа. Дээлийг хоёр хоногт оёдог. Бас хурганы арьс элдэж сураад, хурганы арьс эгнэж дээл хийдэг болсон. 30 хурганы арьс нэг дээл болдог. Би өөрөө эрэгтэй хүүхдүүдтэй ч одоогоор зааж өгч амжаагүй байна.</p>	
9	2022.DoHG.Photo.Baynbold.B.Part1	2022.DoHG.Video.Baynbold.B.Part1	<p>Нэр: Б.Баянболд</p> <p>Ай сав: Уламжлалт арга ухаан</p> <p>Өвийн нэр: Арьс, шир боловсруулах уламжлалт арга</p> <p>Тэрээр мал маллахын хажуугаар үхрийн ширийг боловсруулан суран эдлэл хийж амьдрал ахуйдаа нэмэр болдог. Зундаа гурван эмээл хийчихдэг. Үхэр малаар зарчихдаг. Зундаа сураа шүүлээд, гараараа элддэг. Голчлон олом, жирэм, жолоо, хазаар, ногт хийдэг. Өөрийн сонирхлоор сурсан, хүнээр заалгаагүй.</p>	



10	2022.DoHG.Photo.Purevsuren.D.Part1	2022.DoHG.Video.Purevsuren.D.Part1	<p>Нэр: Д.Пүрэвсүрэн</p> <p>Ай сав: Уламжлалт арга ухаан</p> <p>Өвийн нэр: Бариа заслын аргаар анагаах арга ухаан</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Тэрээр толгой нь доргисон хүүхэд болон ясны бэртэн голдуу барьдаг. Ээжийгээ дуурайгаад л барьж сурсан. Ээж зангилаатай даавуугаар хүүхдийн толгойг хэмжиж барьдаг. Гурван хоног л барьдаг байсан. Манай нагац хугарсан яс барьдаг байсан.</p>	
<p>Матад сум (2022.DoMa)</p> <p>Матад суманд 17-18-нд ажиллав. Матад сумаас үзлэг судалгаанд хамрагдсан өвийн төрлүүд. Үүнд: Монгол гэрийн уламжлалт урлал, Эсгий ширмэл урлал, Мал маллах арга ухаан, Модон сийлбэрийн урлал, Сур харваа, Бариа заслын аргаар анагаах арга ухаан, Хуучир хөгжим тоглох урлаг, Ёочин хөгжим тоглох урлаг, Цол дуудлага, Хурдан морины гийнгоо, Монгол нүүдлийн зан үйл зэрэг өвийн төрлүүд байлаа</p> <p>Матад сумаас үзлэгт хамрагдах 10 өвийн зүйл, 14 өвлөн уламжлагчийн бүртгэл гарсан. Үүнээс Үзлэг судалгаанд хамрагдаагүй 9, шинээр бүртгэлд хамрагдсан 3 өвлөн уламжлагч байсан бөгөөд үүнээс нас барсан 2, нүүдэлчин монголд оролцсон 2, нийт 9 өвлөн уламжлагчийг хээрийн үзлэг судалгаанд хамруулав.</p>				
11	2022.DoMa.Photo.Undrakh.KH.Part1	2022.DoMa.Video.Undrakh.KH.Part1	<p>Нэр: Х.Ундрах</p> <p>Ай сав: Уламжлалт гар урлал</p> <p>Өвийн нэр: Эсгий ширмэл урлал,</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Тэрээр мал маллахын хажуугаар нөхөртэйгөө монгол гэрийн мод хийхээс гадна, гэрийн мод эрээлэх, гэрийн бүрээс оёх, ширдэг ширэх гээд гэртэй холбогдох бүхий л зүйлийг хийдэг. Түүний аав нь гэрийн мод хийдэг, эрээлдэг уран хүн байжээ.</p>	




12	2022.DoMa.Photo.Erdenebat.Z.Part1	2022.DoMa.Video.Erdenebat.Z.Part1	<p>Нэр: З.Эрдэнэбат</p> <p>Ай сав: Уламжлалт гар урлал</p> <p>Өвийн нэр: Монгол гэрийн уламжлалт урлал</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Тэрээр мал маллахын хажуугаар монгол гэрийн мод иж бүтнээр нь хийдэг. Гэрийн тооно, багана, хаалга хийлгэх захиалга их ирдэг. 4, ястай, 6 ястай хийдэг. Мөн хүмүүсийн гуйлтаар гэрийн тооно, хаалга засдаг. Аав нь хаалга, багана хийдэг хүн байсан. Түүний дараа хүүхдүүдэд нь захиалга ирэх болсноор гэрийн мод хийх болжээ.</p>	
13	2022.DoMa.Photo.Oyunbat.D.Part1	2022.DoMa.Video.Oyunbat.D.Part1	<p>Нэр: Д.Оюунбат</p> <p>Ай сав: Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага</p> <p>Өвийн нэр: Үндэсний сур харваа</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Сумын мэргэн харваач. Сурын холбооны дасгалжуулагч багш. Модон сийлбэрийн урлалыг өөрийн сонирхлоороо сурсан. Тэрээр модноос гадна чулуу, эвэр, төмрөөр уран бүтээлээ хийдэг.</p>	




14	2022.DoMa.Photo.Gantumur.Z.Part1	2022.DoMa.Video.Gantumur.Z.Part1	<p>Нэр: З.Гантөмөр</p> <p>Ай сав: Уламжлалт арга ухаан</p> <p>Өвийн нэр: Бариа заслын аргаар анагаах арга ухаан</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Аав минь барьдаг хүн байсан. Ааваараа заалгаж сурсан зүйлгүй ээ. Ааваас хойш хүмүүс аав чинь барьдаг байсан ч барих ёстой гээд л нутгийнхан ирдэг. Өөрийн гарын баримжаагаар л барьдаг. Гар хөлийг бол эвд нь оруулчихдаг. Жоохон хүүхдүүд л их ирдэг. Толгойг бол илж барьдаг. Өвчтэй газар их халуун байдаг, бариад ирэхээр халуун нь буудаг.</p>	
15	2022.DoMa.Photo.Javhlan.G.Part1	2022.DoMa.Video.Javhlan.G.Part1	<p>Нэр: Г.Жавхлан</p> <p>Ай сав: Уламжлалт арга ухаан</p> <p>Өвийн нэр: Бариа заслын аргаар анагаах арга ухаан</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Бариагаа Зундуй гэж хөгшнөөс сурсан. Анх толгой барьдаг байсан, одоо үе мөч мултрах, хүүхэд гэдэс өвдөж, шингэн алдахад барьдаг. Толгойн хоёр талын судас өөр өөрөөр цохилоод байдаг. Голчлон илэх маягаар л барьдаг.</p>	



16	2022.DoMa.Photo.Naranmandakh.Part1	2022.DoMa.Video.Naranmandakh.Part1	<p>Нэр: Б.Наранмандах</p> <p>Ай сав: Ардын язгуур урлаг</p> <p>Өвийн нэр: Хуучир хөгжим тоглох урлаг</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Матад сумын соёлын төвийн эрхлэгч байхдаа үндэсний хөгжим дардаг байлаа. Одоо хөгжмөөсөө холдсон. Энэ нутагт хуучир тоглох сонирхолтой хүн бага байгаад санаа зовниж байна.</p>	
17	2022.DoMa.Photo.Munkhtuya.T.Part1	2022.DoMa.Video.Munkhtuya.T.Part1	<p>Нэр: Т.Мөнхтуяа</p> <p>Ай сав: Ардын язгуур урлаг</p> <p>Өвийн нэр: Цохилуур хөгжим тоглох урлаг (Ёочин)</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Тэрээр ЕБС-д сурч байхдаа 12 настайдаа дугуйланд суралцаж ёочин хөгжим сурсан. Сонсголоороо хөгжим тоглодог тул шавь сургахад жаахан хүндрэлтэй байдаг. Гэсэн ч гурван шавь сургаад байгаа. Сумын 80, 90 жилийн ойгоор хөгжим тоглосон. Ёочин хөгжмөөр тоглох эрэлт хэрэгцээ төдийлөн гараад байдаггүй тул хөндийрөх хандлага гарч байна.</p>	
18	2022.DoMa.Photo.Munkhjargal.J.Part1	2022.DoMa.Video.Munkhjargal.J.Part1	<p>Нэр: Ж.Мөнхжаргал</p> <p>Ай сав: Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд</p> <p>Өвийн нэр: Цол дуудлага</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Сургалтад суугаад, хүүхдийн уралдаанд оролцсон. Сумынхаа наадамд хоёр удаа хурдан морины цол дуудсан.</p>	



19	2022.DoMa.Photo.Zorigbaatar.D.Part1	2022.DoMa.Video.Zorigbaatar.D.Part1	<p>Нэр: Д.Зоригтбаатар</p> <p>Ай сав: Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд</p> <p>Өвийн нэр: Цол дуудлага</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Бөхийн цолыг өөрийн сонирхлоор сурсан. Би бөхөд их дуртай тэгээд Дорнод аймгийн төвд “Их өв сурталтнаас цол дуудах ерөнхий хэв маягийг сурсан. Уул овооны баяр наадам гээд нийтдээ 20-иод удаа цол дуудсан. Одоо өөрөө барилддаг тул цол дуудахгүй байгаа.</p>	
20	2022.DoMa.Photo.Gombosaikhan.J.Part1	2022.DoMa.Video.Gombosaikhan.J.Part1	<p>Нэр: Ж.Гомбосайхан</p> <p>Ай сав: Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага</p> <p>Өвийн нэр: Нүүдлийн зан үйл</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: 1995 оноос дан үхэр маллаж ирсэн. Одоо үхэр, хонь, ямаа, морь, тэмээтэй. Энэ нутагт надаас өөр тэмээн хөсгөөр нүүдэл хийдэг хүн үгүй боллоо. Өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаандаа тэмээгээр л нүүдэл хийдэг. Тэмээн хөсөг, чингэлгүүдээ өөрөө хийдэг.</p>	
<p style="text-align: center;">Хэрлэн сум (2022.DoHe)</p> <p>Хэрлэн суманд 18-19-нд ажиллав. Хэрлэн сумаас үзлэг судалгаанд хамрагдсан өвийн төрлүүд. Үүнд: Ургамлын зүйлээр анагаах арга ухаан, Мал, амьтны эд эрхтнээр анагаах арга ухаан, Уртын дуу, Халх ардын богино дуу, Морин хуур хөгжмийн уламжлалт урлаг, Монгол хөөмийн уламжлалт урлаг, Хурдан морь сойх, уралдуулах мэдлэг оров.</p> <p>Хэрлэн сумаас үзлэгт хамрагдах 10 өвийн зүйлийн 18 өвлөн уламжлагчийн бүртгэл гарсан. Үүнээс Үзлэг судалгаанд хамрагдаагүй 18, нас барсан 1, нүүдэлчин монголд оролцсон 17 хүн байв. Судалгаанд шинээр 8, нийт 11 өвлөн уламжлагчийг хээрийн үзлэг судалгаанд хамруулав.</p>				




21	2022.DoHe.Photo.Balgantseren.D.Part1	2022.DoHe.Video.Balgantseren.D.Part1	<p>Нэр: Д.Балганцэрэн</p> <p>Ай сав: Уламжлалт арга ухаан</p> <p>Өвийн нэр: Ургамлын зүйлээр анагаах арга ухаан</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Тэрээр Халхгол сумын гаралтай. Одоо Хэрлэн суманд амьдардаг. Эм зүйч мэргэжилтэй. Өөрийн мэргэжил дээрээ тулгуурлан эмийн ургамлаар хүмүүсийг анагааж эхэлсэн. Дашдорж, Шарав гэдэг хүмүүсээс голчлон сурсан.</p>	
22	2022.DoHe.Photo.Tsetsegmaa.P.Part	2022.DoHe.Video.Tsetsegmaa.P.Part	<p>Нэр: П.Цэцэгмаа</p> <p>Ай сав: Ардын язгуур урлаг</p> <p>Өвийн нэр: Халх уртын дуу</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Тэрээр цэцэрлэгийн багшаар ажилладаг. Идэрбат багшаар уртын дуу заалгасан. Цэцэрлэгийн 4-5 настай хүүхдүүдэд бэсрэг уртын дуу зааж байна. Урын санд 7-8 дуутай “Хэрлэнгийн баръяа”, “Хан уул”, “Хөөрхөн халиун”, “Цомбон туурайтай хүрэн” гэх мэт дууг дуулдаг.</p>	




23	2022.DoHe.Photo.Soli.Ch.part1	2022.DoHe.Video.Soli.Ch.part1	<p>Нэр: Ч.Соль</p> <p>Ай сав: Ардын язгуур урлаг</p> <p>Өвийн нэр: Халх уртын дуу</p>	
24	2022.DoHe.Photo.Chimedtseren.Ya.Part1	2022.DoHe.Video.Chimedtseren.Ya.Part1	<p>Нэр: Я.Чимэдцэрэн</p> <p>Ай сав: Ардын язгуур урлаг</p> <p>Өвийн нэр: Халх уртын дуу</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Халхгол суманд төрсөн. Ээж минь их сайхан дуулдаг. Бурхан сахиус залахад очиж дуулж баясадаг байсан гэдэг. Өндөр насандаа гараад, охинтойгоо хоёулаа Идэрбат багшаар уртын дуу заалган дуулж байна. “Шалзат баахан шарга”, “Дөрвөн настай халиун”, “Үлэмжийн чанар”, “Хэрлэнгийн баръяа” зэрэг дуу дуулдаг.</p>	
25	2022.DoHe.Photo.Sumiya.S.Part1	2022.DoHe.Video.Sumiya.S.Part1	<p>Нэр: С.Сумъяа</p> <p>Ай сав: Ардын язгуур урлаг</p> <p>Өвийн нэр: Халх уртын дуу</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын харьяат. Ээж минь сайхан дуулдаг, тойглодог хүн байсан. 2016 оноос Идэрбат багшийн уртын дууны сургалтад хамрагдаж дуулж эхэлсэн.</p>	



26	2022.DoHe.Photo.Myagmar.D.Part1	2022.DoHe.Video.Myagmar.D.Part1	<p>Нэр: Д.Мягмар</p> <p>Ай сав: Ардын язгуур урлаг</p> <p>Өвийн нэр: Халх уртын дуу</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Анх Идэрбат багшаар уртын дуу заалгаад 2011 СУИС-д орж Чулуунцэцэг багштай уртын дууны ангийг төгссөн. Одоо Дорнод хөгжимт драмын театрт уртын дуучнаар ажиллаж байна.</p>	
27	2022.DoHe.Photo.Enkhtuya.J.Part1	2022.DoHe.Video.Enkhtuya.J.Part1	<p>Нэр: Ч.Энхтуяа</p> <p>Ай сав: Ардын язгуур урлаг</p> <p>Өвийн нэр: Халх уртын дуу</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Дорнод аймгийн Чойбалсан суманд амьдардаг. Ардын авьяастан Идэрбат багшаар уртын дуу заалгасан “Дөрвөн настай бор” гэдэг дуу дууллаа.</p>	
28	2022.DoHe.Photo.Sarankhuu.B.Part1	2022.DoHe.Video.Sarankhuu.B.Part1	<p>Нэр: Б.Саранхүү</p> <p>Ай сав: Ардын язгуур урлаг</p> <p>Өвийн нэр: Морин хуур хөгжмийн уламжлалт урлаг</p>	




29	2022.DoHe.Photo.Dendev.G.Part1	2022.DoHe.Video.Dendev.G.Part1	<p>Нэр: Г.Дэндэв</p> <p>Ай сав: Ардын язгуур урлаг</p> <p>Өвийн нэр: Монгол хөөмийн уламжлалт урлаг</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: 2013 онд СУИС-ийг Одсүрэн багшийн удирдлага дор төгссөн. Гурван үеийн хөөмийч. Ховд аймгийн Чандмань суманд төрж өссөн. Одоо Дорнодын Хөгжимт драмын театрт хөгжимчнөөр ажиллаж байна.</p>	
30	2022.DoHe.Photo.Iderbat.L.Part1.1 2022.DoHe.Video.Iderbat.L.Part2.1	2022.DoHe.Video.Iderbat.L.Part1.1 2022.DoHe.Video.Iderbat.L.Part2.1	<p>Нэр: Л.Идэрбат,</p> <p>Ай сав: Ардын язгуур урлаг</p> <p>Өвийн нэр: Халх уртын дуу</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Ш.Чимэдцэеэ багшаас анх уртын дуу заалгаж сурсан. СУИС-ийг хөгжмийн багшаар төгсөнө. 2003 оноос Дорнодын театрт уртын дуучнаар ороод 2006 оноос уртын дууны сургагч багш болсон. Урын сандаа 70 орчим уртын дуутай. Давхардсан тоогоор 1600 орчим хүнд уртын дуу, бөх, морины цол дуудах арга ажиллагаа заасан. 2017 онд Аймгийн ЗД-ын захирамжаар “Хэрлэнгийн баръяа” уртын дууны чуулга байгуулагдсан. Үүнд 160 орчим ардын авьяастан хамрагддаг.</p>	



31	2022.DoHe.Photo.Gerelbat.D.Part1	2022.DoHe.Video.Gerelbat.D.Part1	<p>Нэр: Д.Гэрэлбат,</p> <p>Ай сав: Уламжлалт арга ухаан</p> <p>Өвийн нэр: Мал хатгах уламжлалт мэдлэг</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Сүхбаатар аймгийн уугуул хүн. Би энэ нутагт ирж ажиллаж, амьдраад 14 жил болж байна. Морь хатгах аргыг аав, нутгийн ах нараасаа сурсан. Тэр аргаар л морь хатгадаг. Намарт морьдоо барьж усанд сойдог. Ингэж усанд сойх нь морины хур хүчийг тогтоох, цус ялгах онцгой үр дүнтэй. 7-14 морь усанд сойдог. Өдрийн байдлаас хамаараад мориныхоо онцлогоос янз янз байна. Хөлд цус буух, шөрмөсний гэм, уяа, сойлгын гэмийг хагтгаж засдаг. Морь хатгах хутга нь нарийхан хэмжээтэй байх ёстой. Сээрийн сиймхий гэж хамгийн гүн хатгаж, гэмийг авдаг. Хуян хөндүүр авахад нэг см орчим хатгахад болно.</p>	
<p>Чойбалсан сум (Dochoi)</p> <p>Чойбалсан суманд 20-23-нд ажиллав. Чойбалсан сумаас үзлэг судалгаанд хамрагдсан өвийн төрлүүд. Үүнд: Хууч яриа, Модон эдлэл урлал, Монголын уламжлалт арьс ширэн эдлэлийн урлал, Алт мөнгөний дархан, Халх дээл хувцасны уламжлалт урлал байв.</p> <p>Чойбалсан сумаас үзлэгт хамрагдах 11 өвийн зүйлийн 18 өвлөн уламжлагчийн бүртгэл гарсан. Үүнээс үзлэг судалгаанд хамрагдаагүй 13, нас барсан 1, нүүдэлчин монголд оролцсон 2 хүн байв. Судалгаанд шинээр 4, нийт 7 өвлөн уламжлагчийг хээрийн үзлэг судалгаанд хамруулав.</p>				
32	2022.DoChoi.Photo.Gansukh.D.Part1	2022.DoChoi.Video.Gansukh.D.Part1	<p>Нэр: Д.Гансүх</p> <p>Ай сав: Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага</p> <p>Өвийн нэр: Уул, овоо тахих зан үйл</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Гандандаржаалин хийдээс Баянбүрд, Хүүхдийн овоо, Гурван баян уул, Сүмбэр уул, Үнэгт уулыг тахидаг.</p>	




33	2022.DoChoi.Photo.Davaa.Z.Part1	2022.DoChoi.Video.Davaa.Z.Part1	<p>Нэр: З.Даваа</p> <p>Ай сав. Уламжлалт гар урлал</p> <p>Өвийн нэр: Монгол дархны уламжлалт арга ухаан</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Халхгол суманд төрсөн. Мод төмрөөр аль алианаар нь юм хийдэг. Хүмүүсийн захиалгаар голдуу хийдэг. Модоор бол гэрийн тавилга, авдар шүүгээ хийж эхэлж байсан дараа нь гэрийн хаалга, тооно хийсэн. Мөн айлд захиалгаар байшин барьж өгдөг. Төмрөөр усны сав, яндан, хавх, сүйх гэх мэтийг хийж байлаа.</p>	
34	2022.DoChoi.Photo.Batbold.N.Part1	2022.DoChoi.Video.Batbold.N.Part1	<p>Нэр: Н.Батболд</p> <p>Ай сав: Уламжлалт арга ухаан</p> <p>Өвийн нэр: Арьс, шир боловсруулах уламжлалт арга</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Өвөг эцгийнхээ сураар эд хийж байгааг харж сурсан. Чөдөр, хазаар ногт, бугуйл, хийнэ. Би суран эдлэлээ гар аргаар хийдэг. Эхлээд ширээ шүүндээ хийгээд гараад ирэхээр нь элддэг. Энэ зун 5 арьс элдсэн.</p>	
35	2022.DoChoi.Photo.Enkbold.A.Part1	2022.DoChoi.Video.Enkbold.A.Part1	<p>Нэр: А.Энхболд</p> <p>Ай сав: Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд</p> <p>Өвийн нэр: Хууч яриа</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Тэрээр Чойбалсан сумын Соёлын төвийн эрхлэгчээр олон жил ажилласан. Нутаг орныхоо үүх түүхийг цуглуулахаас гадна, дууны шүлэг бичиж, ая зохиодог, сумын үүсэл, хөгжилтэй холбогдох түүх цуглуулдаг.</p>	



	2022.DoChoi.Photo.Purevsuren.N.Part1	2022.DoChoi.Video.Purevsuren.N.Part1	<p>Нэр: Н. Пүрэвсүрэн</p> <p>Ай сав: Уламжлалт гар урлал</p> <p>Өвийн нэр: Монгол дархны уламжлалт арга ухаан</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Тэрээр алт, мөнгөний дарханы ажлыг олон жил хийсэн. Чойбалсан суманд буй ганц алт, мөнгөний дархан бөгөөд захиалга орж ирсэн үед л дарханы ажиллаа хийдэг..</p>	
37	2022.DoChoi.Photo.Tseveensuren.J.Part1	2022.DoChoi.Video.Tseveensuren.J.Part1	<p>Нэр: Ж.Цэвээнрэгзэн</p> <p>Ай сав: Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд</p> <p>Өвийн нэр: Хууч яриа</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Сум орон нутгийн түүх, мал аж ахуйн соёл, түүний хувьсал өөрчлөлтийн тухай яриу.</p>	
38	2022.DoChoi.Photo.Gantsetseg.A	2022.DoChoi.Video.Gantsetseg.A	<p>Нэр: А.Ганцэцэг</p> <p>Ай сав: Уламжлалт гар урлал</p> <p>Өвийн нэр: Халх хувцасны уламжлалт урлал</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Тэрээр Чойбалсан сумын соёлын төвийн эрхлэгчийн алба хашдаг. Бага байхдаа ээжээсээ халх дээл урлах арга ухааныг харж сурсан. Яваандаа өөрийнхөө сонирхлоор оёдол эсгүүрийн хэв намбыг тохируулан дээл урлаж байна. Сумын сурагчдад дээл оёх сургалт явуулдаг.</p>	
Гурванзагал сум (DoGz)				



<p>Гурванзагал суманд 23-25-нд ажиллав. Гурванзагал сумаас үзлэг судалгаанд дараах өвийн төрлүүдийг хамруулан ажиллав. Үүнд: Үзэмчин ардын дуу, Хурдан морь сойх, уралдуулах мэдлэг, Нохойгоор ан хийх, сургах Мал хатгах уламжлалт мэдлэг, Малд төл авхуулах эрдэм, Морины цол дуудлага, Барга ардын бэсрэг урт дуу, Барга идээ ундаа Хуймаг хийх арга зэрэг өвийг үзлэг, судалгаанд хамруулан ажиллав. Гурванзагал сумаас үзлэгт хамрагдах 4 өвийн зүйлийн 4 өвлөн уламжлагчийн бүртгэл гарсан. Үүнээс Үзлэг судалгаанд хамрагдаагүй 3, нас барсан 1, Судалгаанд шинээр 6, нийт 6 өвлөн уламжлагчийг хээрийн үзлэг судалгаанд хамруулав.</p>				
39	2022.DoGz.Photo.Khandarmaa.B.Part1	2022.DoGz.Video.Khandarmaa.B.Part1	<p>Нэр: Б.Хандармаа</p> <p>Ай сав: Ардын язгуур урлаг</p> <p>Өвийн нэр: Барга ардын богино дуу</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Чулуунхороот суманд төрсөн. Халх ястай. Гурванзагал суманд бэр болж ирээд Бараг дуу дуулж сурсан. Тэрээр бараг ардын дуу “жороо жороо улаан” дуулсан. Энэ дуу нь сэтгэлтэй хоёр хосын тухай дуу.</p>	
40	2022.DoGz.Photo.Oyunbaatar.Part1	2022.DoGz.Video.Oyunbaatar.Part1	<p>Нэр: С.Оюунбаатар</p> <p>Ай сав: Байгалийн болон сав шим ертөнцийн тухай мэдлэг, зан үйл</p> <p>Өвийн нэр: Хурдан морь сойх, уралдуулах мэдлэг</p>	




41	2022.DoGz.Photo.Budkhand.J.Part1	2022.DoGz.Video.Budkhand.J.Part1	<p>Нэр: Ж.Будханд</p> <p>Ай сав: Уламжлалт арга ухаан</p> <p>Өвийн нэр: Мал хатгах уламжлалт мэдлэг</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Тэрээр мал маллахын зэрэгцээ хурдан морь уядаг, морь малаа өөрөө хадгадаг.</p>	
42	2022.DoGz.Photo.Tsagaan.Kh.Part1	2022.DoGz.Video.Tsagaan.Kh.Part1	<p>Нэр: Х.Цагаан</p> <p>Ай сав: Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага</p> <p>Өвийн нэр: Мал аж ахуйн холбогдолтой уриа дуудлага</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Тэрээр хонь, ямаа, үхрийн зэрэг мал аж ахуйн холбогдолтой уриа дуудлагыг бага насандаа ээжээсээ сурсан. Одоо мал тойголдог хүн төдийлөн байхгүй болжээ хэмээн ярьж байлаа.</p>	
43	2022.DoGz.Photo.Ganbaatar.Ch.Part1	2022.DoGz.Video.Ganbaatar.Ch.Part1	<p>Нэр: Ч.Ганбаатар</p> <p>Ай сав: Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд</p> <p>Өвийн нэр: Цол дуудлага</p>	




44	2022.DoGz.Photo.Jargalmaa.Ch.Part1	2022.DoGz.Video.Jargalmaa.Ch.Part1	<p>Нэр: Ч.Жаргалмаа</p> <p>Ай сав: Уламжлалт арга ухаан</p> <p>Өвийн нэр: Монгол үндэсний уламжлалт, цай ундаа хийх арга</p>	
<p>Чулуунхороот сум (DoCh)</p> <p>Чойбалсан суманд 25-27-нд ажиллав. Чойбалсан сумаас үзлэг судалгаанд дараах өвийн төрлүүд хамрагдлаа. Үүнд: Хууч яриа, Модон эдлэл урлал, Монголын уламжлалт арьс ширэн эдлэлийн урлал, Алт мөнгөний дархан, Халх дээл хувцасны уламжлалт урлал зэрэг өвийг хамруулан үзлэг, судалгаа хийв. Чойбалсан сумаас үзлэгт хамрагдах 11 өвийн зүйлийн 18 өвлөн уламжлагчийн бүртгэл гарсан. Үүнээс Үзлэг судалгаанд хамрагдаагүй 13, нас барсан 1, нүүдэлчин монголд оролцсон 2 хүн байв. Судалгаанд шинээр 4, нийт 7 өвлөн уламжлагчийг хээрийн үзлэг судалгаанд хамруулав.</p>				
45	2022.DoChu.Photo.Bayraa.B.Part1	2022.DoChu.Video.Bayraa.B.Part1	<p>Нэр: Б.Баяраа</p> <p>Ай сав: Уламжлалт язгуур урлаг</p> <p>Өвийн нэр: Халх уртын дуу.</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Тэрээр Матад сумын уугуул, энэ нутагт шилжин ирсэн. Шавь сургалтаар хүүхдүүдэд уртын дуу заадаг. Л.Идэрбат багшийн шавь</p>	



46	2022.DoChu.Photo.Gantumur.H.Part1	2022.DoChu.Video.Gantumur.H.Part1	<p>Нэр: Н.Гантөмөр</p> <p>Ай сав: Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага</p> <p>Өвийн нэр: Уул овоо тахих зан үйл,</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Баянхаан, Цагаан чулуут, Үүлэн, Цагаан овооны тахилгатай,</p>	
47	2022.DoChu.Photo.Munkhtulga.S.Part1	2022.DoChu.Video.Munkhtulga.S.Part1	<p>Нэр: С.Мөнхтулга</p> <p>Ай сав: Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд</p> <p>Өвийн нэр: Цол дуудлага</p>	
48	2022.DoChu.Photo.Nyamaa.B.Part1	2022.DoChu.Video.Nyamaa.B.Part1	<p>Нэр: Б. Нямаа</p> <p>Ай сав: Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага</p> <p>Өвийн нэр: Буриад хуримын ёс, зан үйл</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Буриадууд бэр гуйхдаа тодорхой дэг баримталдаг. Ер хүний тоо, цаг, зүгийг харгалзана. Бэр гуйхаар очиход бурхны дэргэд гудас тавьсан байвал бурханд нь мөргөөд төрийн ёсоор үрийн хишиг гуйж явна гэж хэлэх ёстой. Охины тал зөвшөөрч байгаа бол зулаа бадраая гэдэг.</p>	



49	2022.DoChu.Photo.Davaakhuu.Part1	2022.DoChu.Video.Davaakhuu.Part1	<p>Нэр: Д.Даваахүү</p> <p>Ай сав: Уламжлалт гар урлал</p> <p>Өвийн нэр: Монголын уламжлалт модон эдлэлийн урлал.</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: 2004 оноос модон эдлэл хийдэг болсон. Морин хуур, төрийн сүлд, цагдаагийн эмблем, малчдын тамганы хайрцаг голчлон хийдэг. Цацлыг айл болгон л хийлгэдэг. Манайд модоор эдлэл хийдэг, сийлбэр хийх хүн байхгүй.</p>	
<p>Дашбалбар сум (2022.DoDa)</p> <p>Дашбалбар суманд 27-29-нд ажиллав. Дашбалбар сумаас дараах өвийн төрлүүдийг үзлэг, судалгаанд хамруулав. Үүнд, Бөө мөргөлийн холбоотой аман уламжлал, Бариа заслын аргаар анагаах арга ухаан, Хурганы арьс элдэх арга ажиллагаа, Буриад бэр гуйх ёс, Шагайн хавчаахай харваа, Чулуу татах мэргэ, Мал хатгах уламжлалт мэдлэг, Морин хуурч, Буриад ардын дуу, Монгол дархны уламжлалт арга ухаан, төмрийн дархан зэрэг өвийн төрлүүдийг судалгаанд хамруулан ажиллаа.</p> <p>Дашбалбар сумаас үзлэгт хамрагдах 34 өвийн зүйлийн 77 өвлөн уламжлагчийн бүртгэл гарсан. Үүнээс Үзлэг судалгаанд хамрагдаагүй 44, нас барсан 21, шилжсэн 1, нүүдэлчин монголд оролцсон 1 хүн байв. Судалгаанд нийт 11 өвлөн уламжлагчийг хээрийн үзлэг судалгаанд хамруулав.</p>				
50	2022.DoDa.Photo.Myadagmaa.L.Part1	2022.DoDa.Video.Myadagmaa.L.Part1	<p>Нэр: Л.Мядагмаа, Шарайд овогтой</p> <p>Ай сав: Ардын язгуур урлаг</p> <p>Өвийн нэр: Бөөгийн ая дан.</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Цагааны угтай бөөгийн удган. Онгод шүтээндээ өргөл өргөөд хүний биед суусан муу зүйлийг зайлуулдаг. Арц, гангаа уугиулж, бөөгийн ая дангаа дууддаг. Тэр үед онгод зулан дөл дээр суудаг хэмээн ярив. Би 5 угтаа тул 5 зул бариад, өргөлд сүү голчлон өргөнө. Тэрээр надад хүнийг бариа заслын аргаар эмчлэх увдис заяасан. Тиймээс би хүнийг өвчин, зовлонгоос гэтэлгэх үйл хийж байна. Дом тарнийн аргаар эмнэдэг.</p>	




51	2022.DoDa.Photo.Yanjmaa.B.Part1	2022.DoDa.Video.Yanjmaa.B.Part1	<p>Нэр: Б.Янжмаа</p> <p>Ай сав: Уламжлалт гар урлал</p> <p>Өвийн нэр: Монголын уламжлалт арьс ширэн эдлэлийн урлал</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Тэрээр хурганы арьсыг уламжлалт аргаар шүүнд хийж элддэг.</p>	
52	2022.DoDa.Photo.Damdindorj.B.Part1	2022.DoDa.Video.Damdindorj.B.Part1	<p>Нэр: Б.Дамдиндорж</p> <p>Ай сав: Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага</p> <p>Өвийн нэр: Буриад хуримын зан үйл</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Буриад хуримын зан үйлд ургахын улаан нарнаар, уулыг давж, усыг гаталж өргөн талаар давхиж ирлээ гээд үгээ хэлдэг. Хүний тоо, эрэгтэй, эмэгтэй ямар хүмүүс оролцох нь их чухал байдаг. Хадаг үгүй охид, хазаар үгүй морь байхгүй гээд хадаг тавих хүмүүсийг хэсэг зогсоодог.</p>	




53	2022.DoDa.Photo.Tseveendorj.Part1	2022.DoDa.Video.Tseveendorj.Part1	<p>Нэр: Б.Цэвээндорж</p> <p>Ай сав: Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага</p> <p>Өвийн нэр: Шагайн харваа</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Хавчаахай харваа, Дашбалбар сумын “Нутгийн домог” ахмадын холбооны настнууд бүлэг болон тоглодог. Нээлт үе, шувтарга үе гээд тус тусад нь сум тавьж тоглоно.</p>	
54	2022.DoDa.Photo.Lkhagvasuren.L.Part1	2022.DoDa.Video.Lkhagvasuren.L.Part1	<p>Нэр: Л.Лхагвасүрэн</p> <p>Ай сав: Байгалийн болон сав шим ертөнцийн тухай мэдлэг, зан үй</p> <p>Өвийн нэр: Чулуу татах мэргэ,</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Тэрээр Хөвсгөл аймгаас ирж суурьшсан Хотгойд хүн. Чулуу татахыг анх эмээгээсээ сурсан. Нутгийнхан ихэвчлэн алдсан малаа асуудаг. Миний чулууны мэргэ төөрдөггүй ээ.</p>	
55	2022.DoDa.Photo.Naranbold.M.Part1	2022.DoDa.Video.Naranbold.M.Part1	<p>Нэр: М.Наранболд</p> <p>Ай сав: Уламжлалт арга ухаан</p> <p>Өвийн нэр: Бариа заслын аргаар анагаах арга ухаан</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: ааваасаа өвлөн авсан, цагааны талын онгодтой. Аав минь өнгөрөхөөсөө өмнө аавынхаа өвийг аваарай гэж хэлж байсан. Ээжийн тал минь онгодтой хүмүүс байсан. Тэгээд би ээж аавынхаа хоёулынх нь өвийг авсан.</p>	




56	2022.DoDa.Photo.Uuganbayr.D.Part1	2022.DoDa.Video.Uuganbayr.D.Part1	<p>Нэр: Д.Ууганбаяр</p> <p>Ай сав: Уламжлалт арга ухаан</p> <p>Өвийн нэр: Мал ханах уламжлалт мэдлэг</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Тэрээр Сүхбаатар аймагт алдарт уяачийнд гурван жил туслах уяачаар ажиллахдаа морь ханах арга ухаанд суралцсан. Энэ морины шөрмөс нь сунасан байна. Шөрмөсийг нь нэвт хатгаж гэмийн арилгана.</p>	
57	2022.DoDa.Photo.sarankhuyag.Yu.Part1	2022.DoDa.Video.sarankhuyag.Yu.Part1	<p>Нэр: Ю.Саранхуяг</p> <p>Ай сав: Ардын язгуур урлаг</p> <p>Өвийн нэр: Морин хуур хөгжмийн уламжлалт урлаг</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Тэрээр Дашбалбар суманд 1998 оноос ажиллаж байна. 2019 оноос шавь сургалтаар хэдэн хүүхдэд морин хуур хөгжим зааж сургасан байна. Нийт 12 хүүхдэд анхан шатнаас нь заагаад явж байна. Манай соёлын төв гэхэд үндэсний хөгжим байхгүй нь бэрхшээлтэй байна.</p>	
58	2022.DoDa.Photo.Chimeddorj.Ts.Part1	2022.DoDa.Video.Chimeddorj.Ts.Part1	<p>Нэр: Ц.Чимэджав</p> <p>Ай сав: Ардын язгуур урлаг</p> <p>Өвийн нэр: Буриад богино дуу.</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Арван найман наснаасаа л дуулж байсан. “Алтан шар нар”, “Аав ээжийн захиас” гээд олон буриад дуу бий. Сумын арга хэмжээнүүдэд голчлон ирж дуулдаг</p>	



59	2022.DoDa.Photo.Tsevelmaa.G.Part1	2022.DoDa.Video.Tsevelmaa.G.Part1	<p>Нэр: Г.Цэвэлмаа</p> <p>Ай сав: Ардын язгуур урлаг</p> <p>Өвийн нэр: Буриад богино дуу,</p>	
60	2022.DoDa.Photo.Tumur.Z.Part1	2022.DoDa.Video.Tumur.Z.Part1	<p>Нэр: З.Төмөр</p> <p>Ай сав: Уламжлалт гар урлал</p> <p>Өвийн нэр: Монгол дархны уламжлалт арга ухаан.</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Бөөгийн эдлэл хэрэгслийг голчлон хийдэг. Нэг хүнд зориулж нэг л хийдэг. Нэг хүний бүтэн хэрэгсэл хийхэд долоо хоног ордог. Дарханд туслах хөөрөгч, төмөр давтахад тусалдаг хүн гэж байдаг байж. Одоо тийм биш байна. Би бол бөө хүн биш. Хүмүүс яах вэ Дорлиг (дархны иж бүрэн багаж бүхий бурхан) өмнө тавагтай идээ тавина. Энэ нь тэр далд харагдаж байгаа юманд тавьж байгаа юм. Айлд хөөргөө бариад очдоггүй, хийлгэх хүн ирж хийлгэнэ.</p>	
<p style="text-align: center;">Баяндун сум (DoBadu)</p> <p>Баяндун суманд 29-31-нд ажиллав. Баяндун сумаас үзлэг судалгаанд дараах өвийн төрлийг хамруулан ажиллав. Үүнд: Монголын уламжлалт арьс ширэн эдлэлийн урлал, Шагайн наадгай, Хүүхэдтэй холбоотой ёс, зан үйл, Бүүвэйн дуу, Шог дуу, Бөхийн цол дуудлага, Харилцаа дуу, Цагаан идээ бэлтгэх уламжлалт арга ажиллагаа, Дээл хувцасны уламжлалт урлал, Уул овоо тахих зан үйл, Буриад ардын богино дуу зэрэг өвүүдтэй танилцаж, үзлэг судалгаа хийв. Баяндун сумаас үзлэгт хамрагдах 20 өвийн зүйлийн 33 өвлөн уламжлагчийн бүртгэл гарсан. Үүнээс Үзлэг судалгаанд хамрагдаагүй 28, Шинээр бүртгэгдсэн 6, нийт 11 өвлөн уламжлагчийг хээрийн үзлэг судалгаанд хамруулав.</p>				




61	2022.DoBadu.P hoto.Hurelchulu un.Ch.Part1	2022.DoBadu.Video.H urelchuluun.Ch.Part1	<p>Нэр: Ч.Хүрэлчулуун</p> <p>Ай сав: Уламжлалт гар урлал</p> <p>Өвийн нэр: Монголын уламжлалт арьс ширэн эдлэлийн урлал</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Би ХААИС-ийг фермерийн ангиар төгссөн. Сургуулиа төгсөд төрөлх сумандаа мал аж ахуй эрхэлж байна. Хүмүүс гоёлын хазаар, хударга их сонирхож байна. Гоёлын суран эдлэл хийж байна. Сурын эдэлгээг уртасгахын тулд адууны тосоор тосолдог. Адууны тосоор тослохоор намилзсан шар өнгөтэй болдог.</p>	
62	2022.DoBadu.P hoto.Giimaa.P.P art1	2022.DoBadu.Video.Gi imaa.P.Part1	<p>Нэр: П.Гиймаа</p> <p>Ай сав: Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага</p> <p>Өвийн нэр: Үгэн тоглоомын уламжлалт төрлүүд</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Миний хөгшин ээж “Хоёр лам хорин чөтгөр” гэдэг тоглоом зааж өгч байв. Энэ тоглоомын дүрэм нь хоёр лам чөтгөрүүдтэй тоо тоолж тоглоод, өөрсдийгөө баригдахгүй амиа аврах ёстой. уран сэтгэмж шаардсан тоглоом юм. Одоо ач зээ нараараа тоглуулж байна.</p>	




63	2022.DoBadu.P hoto.Dolgormaa .Ts.Part1	2022.DoBadu.Video.D olgormaa.Ts.Part1	<p>Нэр: Ц.Долгормаа</p> <p>Ай сав: Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага</p> <p>Өвийн нэр: Хүүхэдтэй холбоотой ёс, зан үйл, найр</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Ахмадуудын “Наранбулаг хамтлаг” 2010 онд байгуулагдсан. Олон улсын Алтаргана наадамд оролцож тусгай байр шалгарч байсан амжилттай. Тэдний зорилго өв уламжлалаа олон түмэнд хүргэх, мартагдаж байгаа өв соёлыг авч үлдэх зорилгоор байгуулагдсан. Тэд бидэнд дутуу төрсөн хүүхдийг тогтоох, эерүүлэх зан үйлийн талаар сонирхуулав.</p>	
64	2022.DoBadu.P hoto.Yumjir.D.P art1	2022.DoBadu.Video.Y umjir.D.Part1	<p>Нэр: Д.Юмжир</p> <p>Ай сав: Ардын язгуур урлаг</p> <p>Өвийн нэр: Бүүвэйн дуу.</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Буриад ардын бүүвэйн дуу</p>	
65	2022.DoBadu.P hoto.Radnaatse ren.L.Part1	2022.DoBadu.Video.R adnaatseren.L.Part1	<p>Нэр: Л.Раднаацэрэн</p> <p>Ай сав: Ардын язгуур урлаг</p> <p>Өвийн нэр: Буриад богино дуу.</p>	




67	2022.DoBadu.P hoto.Batbayar.K h.Part1	2022.DoBadu.Video.B atbayar.Kh.Part1	<p>Нэр: Н.Батбаяр</p> <p>Ай сав: I. Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд</p> <p>Өвийн нэр: Цол дуудлага</p>	
68	2022.DoBadu.P hoto.Tsedenbay r.G.Part1	2022.DoBadu.Video.T sedenbayr.G.Part1	<p>Нэр: Г.Цэдэнбаяр</p> <p>Ай сав: Ардын язгуур урлаг</p> <p>Өвийн нэр: Харилцаа дуу</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: “Наранбулаг хамтлаг”-ийн ахмадууд өв уламжлалаа олон түмэнд хүргэх мартагдаж байгаа өв соёлыг авч үлдэх зорилгоор Буриад ардын харилцаа дуу, хошин дууг дуулдаг.</p>	
69	2022.DoBadu.P hoto.Munkhtulg a.Ts.Part1	2022.DoBadu.Video.M unkhtulga.Ts.Part1	<p>Нэр: Ц.Мөнхтуяа</p> <p>Ай сав: Уламжлалт арга ухаан</p> <p>Өвийн нэр: Монгол үндэсний уламжлалт, цай ундаа хийх арга</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Идээ ундаа хийх арга ажиллагаа, Цагаан идээ боловсруулах арга ажиллагаа. Ээж аав минь малчин хүмүүс, ээж минь өглөө 3 цагт үнээгээ саадаг. Сүүгээ тасагт тушаадаг. Би 6 настайдаа л 2 үхэр сааж сурсан. Тэр үеэс л ээж аавдаа тусалж ээдэмцэр боловсруулж, түүнийгээ улсад тушаадаг байсан. Тэгж л сурч байлаа</p>	



70	2022.DoBadu.P hoto.Munkhtsen gel.L.Part1	2022.DoBadu.Video.M unkhtsengel.L.Part1	<p>Нэр: Л.Мөнхцэнгэл</p> <p>Ай сав: Урамжлалт гар урлал</p> <p>Өвийн нэр: Буриад хувцасны уламжлалт урлал</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Бүх төрлийн дээл оёдог. Буриад дээл, малгай, ажлын хувцас гээд бүгдийг оёно. Би өөрөө л оёод сурчихсан, хүний дээл хувцас хараад л оёж сурсан. Өдөр шөнөгүй суухад 2 өдөрт дээл оёно. Оёдол бол маш их ажиллагаатай нөр их хөдөлмөр ордог.</p>	
71	2022.DoBadu.P hoto.Enkhtaivan .Kh.Part1	2022.DoBadu.Video.E nkhtaivan.Kh.Part1	<p>Нэр: Н.Энхтайван</p> <p>Ай сав: Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага</p> <p>Өвийн нэр: Хүүхэдтэй холбоотой ёс, зан үйл, найр</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Тооно тайх зан үйл. Манай нутаг орныхон 2005 онд нутаг орны ахмадууд мартагдсан өвөө сэргээх санал тавиад “Тоонотын баяр” гэдгийг зохион байгуулж байна. Мартагдсан ёс заншлаа сэргээх зорилготой. Бүх буриад сумууд ирж оролцдог. Энэ үеэр “Тоонот тайх ёс”-ыг үзүүлдэг.</p>	
72	2022.DoBadu.P hoto.Oyun.Z.Par t1	2022.DoBadu.Video.O yun.Z.Part1	<p>Нэр: З.Оюун</p> <p>Ай сав: Ардын язгуур урлаг</p> <p>Өвийн нэр: Буриад ардын дуу</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Би улсын тэргүүний уран сайханч. Урын санд барагтайхан л дуунуудыг мэднэ л гэж үзэж байна. 11 настайгаасаа “Аав ээжийн сургаал” гэж дууг дуулж тайзан дээр гарч, 1971 онд бүх ард түмний урлагийн үзлэгээс аймагт 3-р байрт шалгарч хүрэл медаль авч байсан.</p>	
Баян-уул сум (DoBaU)				



<p>Баян-уул суманд 10 дугаар сарын 31-нд ажиллав. Баян-Уул сумаас үзлэг судалгаанд дараах өвийн төрлүүд хамрагдсан. Үүнд: Ургамлын зүйлээр анагаах арга ухаан, Модон сийлбэрийн урлал, Буриад уртын дуу, Нум сум урлал, Зээгт наамал, Бөө мөргөлийн зан үйл, Ходок тэрэг хийх уламжлалт арга, Ереөл зэрэг өвүүдтэй танилцаж, үзлэг судалгаа авав. Баян-Уул сумаас үзлэгт хамрагдах 19 өвийн зүйлийн 30 өвлөн уламжлагчийн бүртгэл гарсан. Үүнээс Үзлэг судалгаанд хамрагдаагүй 23, нас барсан 1, шилжсэн 1, шинээр бүртгэгдсэн 1, нүүдэлчин монголд оролцсон 5 хүн байв. Судалгаанд нийт 8 өвлөн уламжлагчийг хээрийн үзлэг судалгаанд хамруулав.</p>				
73	2022.DoBaU.Photo.Batbayar.Kh.Part1	2022.DoBaU.Video.Batbayar.Kh.Part1	<p>Нэр: Ц.Баатар</p> <p>Ай сав: Уламжлалт арга ухаан</p> <p>Өвийн нэр: Ургамлын зүйлээр анагаах арга ухаан</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: 2002 оноос ургамал түүж эхэлсэн. Сургуульд ороогүй байхдаа нутгийн ахмадууддаа тусалж, ургамал түүж байхдаа ургамал таньдаг болсон. 100 орчим ургамал таньдаг. Жамсран зэрэг өвгөчүүдээс ургамал, түүний эрдэмт чанарыг надад харамгүй зааж сургажээ. Мөн би өөрийн сонирхлоор олон ургамлын эмчилгээний чанарыг таньж мэдсэн.</p>	
74	2022.DoBaU.Photo.Janchivdorj.L.Part1	2022.DoBaU.Video.Janchivdorj.L.Part1	<p>Нэр: Л.Жанчивдорж</p> <p>Ай сав: Уламжлалт гар урлал</p> <p>Өвийн нэр: Монголын уламжлалт модон эдлэлийн урлал</p>	


75	2022.DoBaU.Photo.Myagmarsuren.B.Part1	2022.DoBaU.Video.Myagmarsuren.B.Part1	<p>Нэр: Б.Мягмарсүрэн</p> <p>Ай сав: Ардын язгуур урлаг</p> <p>Өвийн нэр: Буриад уртын дуу</p>	
76	2022.DoBaU.Photo.Damdindorj.B.Part1	2022.DoBaU.Video.Damdindorj.B.Part1	<p>Нэр: Б.Дамдиндорж</p> <p>Ай сав: Уламжлалт гар урлал</p> <p>Өвийн нэр: Буриад нум сум урлал</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: 2003 оноос өнөөг хүртэл нум сум хийх, засварлах ажил хийж байна. Нум сум хийхэд үхрийн шөрмөсийг давтаж янзлаад хийнэ. Нуманы элгийг эврээр хийнэ. Янгир, Хайнагийн эврээр хийж байна. Одоогоор хятадаас эвэр авч хийж байна. Манж чин улсын үед дэлгэрсэн том урт хийж байна.</p>	
77	2022.DoBaU.Photo.Oyuntsetseg.Ch.Part1	2022.DoBaU.Video.Oyuntsetseg.Ch.Part1	<p>Нэр: Ч.Оюунцэцэг</p> <p>Ай сав: Уламжлалт гар урлал</p> <p>Өвийн нэр: Зээгт наамлын уламжлалт урлал</p>	



78	2022.DoBaU.Photo.Oyunbaatar.Ts.Part1	2022.DoBaU.Video.Oyunbaatar.Ts.Part1	<p>Нэр: Ц.Оюунбаатар</p> <p>Ай сав: Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд</p> <p>Өвийн нэр: Бөө мөргөлийн холбоотой аман илэрхийлэл</p>	
79	2022.DoBaU.Photo.Ganbat.D.Part1	2022.DoBaU.Video.Ganbat.D.Part1	<p>Нэр: Д.Ганбат</p> <p>Ай сав: Уламжлалт гар урлал</p> <p>Өвийн нэр: Ходок тэрэг хийх уламжлалт арга</p>	
80	2022.DoBaU.Photo.Oyunchimeg.Part1	2022.DoBaU.Video.Oyunchimeg.Part1	<p>Нэр: Д.Оюунчимэг</p> <p>Ай сав: Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд</p> <p>Өвийн нэр: Буриад аман аялгуу</p>	
<p>Цагаан-Овоо сум (DoTsaU)</p> <p>Цагаан овоо суманд 11 дүгээр сарын 1-нд ажиллав. Цагаан-овоо сумаас үзлэг судалгаанд дараах өвийн төрлүүд хамрагдав. Үүнд: Буриад ардын богино дуу, Модон сийлбэрийн урлал, Угийн бичиг хөтлөх монгол уламжлалт мэдлэг, Монгол дарханы уламжлалт урлал, Хууч яриа, Тэнгэр, эрхэс, цаг агаар шинжих уламжлалт мэдлэг зэрэг өвтэй танилцаж, үзлэг судалгаа авав. Цагаан овоо сумаас үзлэгт хамрагдах 26 өвийн зүйлийн 35 өвлөн уламжлагчийн бүртгэл гарсан. Үүнээс Үзлэг судалгаанд хамрагдаагүй 24, нас барсан 3, нүүдэлчин монголд оролцсон 6 хүн байв. Судалгаанд нийт 11 өвлөн уламжлагчийг хээрийн үзлэг судалгаанд хамруулав.</p>				



81	2022.DoTsaU.P hoto.Oyun.D.Pa rt1	2022.DoTsaU.Video.Oyun.D.Part1	<p>Нэр: Д.Оюун</p> <p>Ай сав: Ардын язгуур урлаг</p> <p>Өвийн нэр: Буриад богино дуу</p>	
82	2022.DoTsaU.P hoto.Mishigdorj. D.Part1	2022.DoTsaU.Video.Mishigdorj.D.Part1	<p>Нэр: Д.Мишигдорж</p> <p>Ай сав: Уламжлалт гар урлал</p> <p>Өвийн нэр: Монгол дархны уламжлалт арга ухаан</p>	
83	2022.DoTsaU.P hoto.Byambadorj. j.S.Part1	2022.DoTsaU.Video.Byambadorj.S.Part1	<p>Нэр: С.Бямбадорж</p> <p>Ай сав: Уламжлалт арга ухаан</p> <p>Өвийн нэр: Угийн бичиг хөтлөх монгол уламжлалт мэдлэг</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Тэрээр Цагаан-овоо сумын ИТХ-ын даргын алба хашдаг. Өрөөнийхөө ураг удмынхан үе сүлжлийг тодруулж, угийн бичгээ шинэчлэн бичиж байгаа аж. Өөрийнхөө аавын талын үе сүлжлийг өөрөөс дээшээ есөн үе хүртэл гаргаж, ураг удмынхандаа тарааж өгчээ. Түүний хэлэхээр угийн бичиг гэдэг тухайн овгийн гишүүдийн товч мэдээлэл багтдаг.</p>	



			Тухайлбал, хэдэн хүүхэдтэй ямар ажил хийж байсан тухай. Гэр бүл салсан эсэх, зан аашны тухай дэлгэрэнгүй мэдээлэл багтаадаг байсан тул нууц байдлаар хадгалдаг ёстой гэнэ. Ер нь барагтай бол өөрийнхөө уг удмын талаарх мэдээллийг бусдад хуваалцдаггүй гэнэ.	
84	2022.DoTsaU.P hoto.Gurjav.G.P art1	2022.DoTsaU.Video.Gurjav.G.Part1	<p>Нэр: Г.Гүржав</p> <p>Ай сав: Уламжлалт гар урлал</p> <p>Өвийн нэр: Бөөгийн хувцас урлал,</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Дорлигтой дархан хүн, бөгөөд уламжлалт хөөрөг ашиглан төмрөөр бөөгийн эд хэрэгсэл хийдэг, дарханы ширгээлэг аргаар өвчин анагаадаг.</p>	
85	2022.DoTsaU.P hoto.Lkhamsure n.B.Part1	2022.DoTsaU.Video.Lkhamsuren.B.Part1	<p>Нэр: Б.Лхамсүрэн</p> <p>Ай сав: Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд</p> <p>Өвийн нэр: Хууч яриа,</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Тэрээр одоо 91 настай бөгөөд Буриадуудын нүүж ирсэн үе болон тэдний ахуй амьдралын талаар ярих.</p>	




86	2022.DoTsaU.P hoto.Munkhsaik han.L.Part1	2022.DoTsaU.Video.Munkhsaikhan.L.Part1	<p>Нэр: Л.Мөнхсайхан</p> <p>Ай сав: Байгалийн болон сав шим ертөнцийн тухай мэдлэг, зан үйл</p> <p>Өвийн нэр: Тэнгэр, эрхэс, цаг агаар шинжих уламжлалт мэдлэг</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Тэрээр мичдийн тохилгоор цаг аясыг тооцдог байна. Мөн мал маллах арга ажиллагаанд баримтлах мичдийн тооллын тохиолыг баримталж ажиглах ёстой хэмээн ярьж байв. Амьтны байр байдал, цаг агаарын аясыг од сар, мичдийг ажиглаж тооцоолох бүрэн боломжтой. Мичдийн тохиолын арга бол хуучны монгол цаг тооны бичиг хэмээв.</p>	
<p style="text-align: center;">Сэргэлэн сум (DoSe)</p> <p>Сэргэлэн суманд 11 дүгээр сарын 3-нд ажиллав. Сэргэлэн сумаас үзлэг судалгаанд дараах өвүүд хамрагдсан. Үүнд: Үзэмчин ардын бэсрэг дуу, Домог, Магтаал, Сур харваа, Жилийн цай, үзэмчин түмний цай уух ёслол, Үзэмчин хурим, Монголын уламжлалт арьс ширэн эдлэлийн урлал, Бөх, морины цол дуудлага зэрэг өвтэй танилцаж, судалгаа авав. Сэргэлэн сумаас үзлэгт хамрагдах 14 өвийн зүйлийн 21 өвлөн уламжлагчийн бүртгэл гарсан. Үүнээс Үзлэг судалгаанд хамрагдаагүй 14, нас барсан 2, шилжсэн 1, нүүдэлчин монголд оролцсон 1 хүн байв. Судалгаанд нийт 7 өвлөн уламжлагчийг хээрийн үзлэг судалгаанд хамруулав.</p>				
87	2022.DoSe.Phot o.Tumurbaatar. D.Part1	2022.DoSe.Video.Tumurbaatar.D.Part1	<p>Нэр: Д.Төмөрбаатар</p> <p>Ай сав: Ардын язгуур урлаг</p> <p>Өвийн нэр: Үзэмчин -Дарьганга уртын дуу</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Намайг Тайх овогтой Дашдоржийн Төмөрбаатар гэдэг. Би үзэмчин угсаатны бүлгийн хүн. Найр наадам үзэмчин угсаатны бэсрэг уртын дуу даалдаг. Аав ээжээсээ сурсан. Мөн Амьбөхийн сумьяа гэдэг хүнээс хэд хэдэн дуу заалгаж сурсан.1976 оноос дуу дуулж эхэлсэн. Явсан урлагийн наадмуудаас медаль авч байсан. Манай нутагт найр “эртийн</p>	


			цагаан” дуугаар эхэлдэг. “Нарийн хөх морь”, “алтан дүртэй чигжүүхэй” гэх мэт дуу найранд дуулагдаж байна.	
88	2022.DoSe.Photo.Gurragchaа.Kh.Part1	2022.DoSe.Video.Gurragchaа.Kh.Part1	<p>Нэр: Н.Гүррагчаа Ай сав: Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд Өвийн нэр: Домог Баримтжуулсан тухай мэдээлэл: Намайг Нэхийтийн Гүррагчаа гэдэг. Би борог омогтой, үзэмчин угсаатан. Манай сумын дөрөвдүгээр багийн нутагт галын гол гэж бий. Түүний зүүн эрэгт хийдийн туурь бий. Энэ хийдийг гүнгийн хийд гэдэг байна. Энэ хүрэнээс хойш Очир хүрээ гэдэг хайрхан байдаг. Нутгийн тайжийн хүү өнгөрсөн тул хүүгээ тэр газар оршоожээ. Газар ус догширч хийдийн лам нарт өвчин гарах болсон. Хийдийн лам нар дарж чадаагүй. Халхын тамгатай нутгаас асуухад их ус гаталж нүүхийг зөвлөсөн байдаг. Гүнгийн хийдийг Галын голыг давж, одоогийн Булган сумын орчим нүүж очсон. Харин Очир хүрээ ууланд нутаглуулсан хүүгийн шарилыг Яхын нуурын Баянхошуу гэдэг хар чулуутай газар шилжүүлэн оршуулж, хонины нэхийний хэмжээтэй чулуунд майнын зургаан үсгийг сийлсэн гэдэг.</p>	



89	2022.DoSe.Photo.Enkhzaya.D.Part1	2022.DoSe.Video.Enkhzaya.D.Part1	<p>Нэр: Д.Энхзаяа Ай сав: Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд Өвийн нэр: Магтаал Баримтжуулсан тухай мэдээлэл: Үзэмчин ардын “Гомон захирагчийн үг”, “найрын бөх” гэдэг магтаал хэллээ. Намайг Урианхай овогт Доржжамцын Энхзаяа гэдэг. Би эхээс арван гурвуулаа. Манай аав ээж урлагийн хүмүүс байсан. Сайхан дуулж хуурддаг. Би энэ нутагт бэр бол ирсэн. Дорнод аймгийн Хөлөнбуйр суманд төрсөн.</p>	
90	2022.DoSe.Photo.Battuya.T.Part1	2022.DoSe.Video.Battuya.T.Part1	<p>Нэр: Т.Баттуяа Ай сав: Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага Өвийн нэр: Сурын харваа Баримтжуулсан тухай мэдээлэл: Түүний нөхрийг Ариунбат гэдэг. Анх нөхрөөрөө заалгаж сур харваж сурчээ. Түүнийг гэр бүлээрээ Сэргэлэн суманд ирэхэд наадмаар сурын харвааны тэмцээнд оролцох хүнгүй байжээ. Нөхрийнхөө хамт сүүлийн гурван жил сур харвааны сургалт зохион байгуулжээ. Үүний үрд дүнд улсын баяраар Сэргэлэн суманд эрэгтэй эмэгтэй төрөл мэргэн харваачид эрхий мэргэнээ сорин наадаж байна.</p>	



91	2022.DoSe.Photo.Serjibyamba.B.Part1	2022.DoSe.Video.Serjibyamba.B.Part1	<p>Нэр: Б. Сэржибямба Ай сав: Уламжлалт арга ухаан Өвийн нэр: Цагаан идээ бэлтгэх уламжлалт арга Баримтжуулсан тухай мэдээлэл: Жилийн цайг сар шинийн баярын дараа сайн өдөр товлож ах дүү нараа заллага хүргэснээр жилийн цай уулгах ёслол болдог. Цай урьж уулгах нь нэг талаар ураг удмынхны харилцааг бөхөлж байдаг бол нөгөө талаар хүндлэл болдог байна.</p>	
92	2022.DoSe.Photo.Tumurbaatar.Ts.Part1	2022.DoSe.Video.Tumurbaatar.Ts.Part1	<p>Нэр: Ц. Төмөрбаатар Ай сав: Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд Өвийн нэр: Хууч яриа Баримтжуулсан тухай мэдээлэл: Бярган овогийн Цогбадрахын Төмөрбаатар гэдэг. Тэтгэвэрт сууж байна. Үзэмчин угсаатны хуримын зан үйлийн тухай ярив. Их бага хэмжээний 30 орчим хуримд оролцож байсан. Үзэмчин хуримын нэг онцлог Бэргэн гэж хүндтэй хүн явдаг. Энэ хүн бэр буулгах үндсэн үүргийг гүйцэтгэнэ. Бэр ирэхэд “бэр мөргүүлэх ёс” гүйцэтгэнэ. Бэрийн дэргэд хоёр талын бэргэн байлцана. Хоёр бэргэн бэрийн үсийг хагалж, гал голом болон ивээл жилтэй хүндтэй хүн мөргүүлдэг.</p>	



93	2022.DoSe.Photo.Batchuluun.M.Part1	2022.DoSe.Video.Batchuluun.M.Part1	<p>Нэр: М.Батчулуун Ай сав: Уламжлалт гар урлал Өвийн нэр: Монголын уламжлалт арьс ширэн эдлэлийн урлал</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Мэндбаяр овогтой Батчулуун гэдэг. Сур суран эдлэл, суран харваа ихээр сонирхдог. Соёлын суран эдлэл хийж байна. Үндсэн хийцийг орчин үеийн залуучуудын хүсэл сонирхолд нийцүүлэн урлаж байна. Хүмүүс морины эдлэл хэрэглэлийг ихээхэн сонирхож байна.</p>	
<p style="text-align: center;">Баянтүмэн сум (DoBaTu)</p> <p>Баянтүмэн суманд 11дүгээр сарын 4-нд ажиллав. Баянтүмэн сумаас үзлэг судалгаанд Монголын уламжлалт модон эдлэлийн урлал, араг хийх арга ажиллагаа, Модон сийлбэрийн урлал, Монгол уран бичлэг, Үзэмчин царцаасан будаа хийх арга, Баримлын урлал, Шуумлын урлал зэрэг өвүүдийг бүртгэв. Баянтүмэн сумаас үзлэгт хамрагдах 12 өвийн зүйлийн 16 өвлөн уламжлагчийн бүртгэл гарсан. Үүнээс Үзлэг судалгаанд хамрагдаагүй 11, Судалгаанд нийт 5 өвлөн уламжлагчийг хээрийн үзлэг судалгаанд хамруулав</p>				
94	2022.DoBaTu.Photo.Batjargal.Sh.Part1	2022.DoBaTu.Video.Batjargal.Sh.Part1	<p>Нэр: Ш.Батжаргал Ай сав: Уламжлалт гар урлал Өвийн нэр: Монголын уламжлалт модон эдлэлийн урлал</p> <p>Баримтжуулсан тухай мэдээлэл: Намайг Шуушангай овогтой Батжаргал гэдэг. Аваасаа сурсан. Би гурав дахь үеийн өвлөн уламжлагч. Араг хийхэд бургас огтлон. Тэмээний ширээр үддэг. Бургасаа өвлийн цагт Хэрлэн голын бургаснаас авч байна.</p>	



95	2022.DoBaTu.P hoto.Tsengel.O. Part1	2022.DoBaTu.Video.Tsengel.O.Part1	<p>Нэр: О.Цэнгэл Ай сав: Уламжлалт гар урлал Өвийн нэр: Модон сийлбэрийн урлал Намайг Очирхуягийн Цэнгэл гэдэг. Дорнод аймгийн Баянтүмэн сумын иргэн. Миний аавын талд гарын уртай хүмүүс байсан. Тэднээс л юм хийж сурсан болов уу гэж бодоог. Би мужаан мэргэжилтэй. Би модоор авдар, шатар, модон хуйван, ган тулга хийсэн.</p>	
96	2022.DoBaTu.P hoto.Tsetsegdar i.Part1	2022.DoBaTu.Video.Tsetsegdari.Part1	<p>Нэр: Э.Цэцэгдарь Ай сав: Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд Өвийн нэр: Монгол уран бичлэг. Баримтжуулсан тухай мэдээлэл: Шавь нартаа зааж байна. Уран бичлэгийн уралдаанд 2 удаа оролцож түрүүлж байсан. Энхжаргалын Цэцэгдарь гэдэг. Сүхбаатар сумын Наран суманд төрсөн. Хөхийд овгийн хүн. Монгол хэл бичиг уран зохиолын багш. Монгол бичгийн соёлыг дэлгэрүүлэхийг хичээж явдаг.</p>	
97	2022.DoBaTu.P hoto.Jodovzagd al.S.Part1	2022.DoBaTu.Video.Jodovzagdal.S.Part1	<p>Нэр: С.Жодовзагдал Ай сав: Уламжлалт арга ухаан Өвийн нэр: Монголын үндэсний уламжлалт, цай ундаа хийх арга Баримтжуулсан тухай мэдээлэл: Царцаасан будаа хийх арга ажиллагаа. Бидний дээр дурдсан Үзэмчин угсаатны бүлгийн жилийн цайны ёслолын хамгийн чухал хэрэглэгдэхүүн царцаасан будаа юм. Царцаасан будааг хийхдээ засаж янзалсан чулуун дээр шар будаагаа асгаад дээрээс бөөрхий чулуугаар дарж</p>	



			<p>няцалдаг. Үүнийг “ёргуулдах” гэнэ. Няцалсан шар будаа дээрээ шар тосоо хийж багсраад гадаа гаргаж царцаана. Царцсаны дараа жилийн цай уух ёслолын үеэр аягатай идээ боорцгийн дээр царцаасан будаагаа хийгээд дээрээс нь сүүтэй цай хийж, зочиндоо хоёр гардан барьдаг байна.</p>	
98	2022.DoBaTu.P hoto.Naranbat. G.Part1	2022.DoBaTu.Video.Naranbat.G.Part1	<p>Нэр: Г.Наранбат Ай сав: Уламжлалт гар урлал Өвийн нэр: Баримлын урлал Баримтжуулсан тухай мэдээлэл: Тайж овогтой Гомбосүрэнгийн Наранбат гэдэг. Үзэмчин угсаатан. Багасаа зураг зурах дуртай байсан. Бага насны мөрөөдлийг мэргэжил болгоё гэж бодоо ИЗОУИС-д уран барималчин мэргэжлээр сурч төгссөн. Одоо хайчилбар, зураг зурж байна. Мөн цаасан шуумал хийж байна.</p>	
<p>Булган сум (DoVi)</p> <p>Булган суманд 11-р дүгээр сарын 5-нд ажиллав. Булган сумаас үзлэг судалгаанд Морин хуурч, Мал маллах арга ухаан, Хурдан морины марзай, Бөхийн цол дуудлага зэрэг өвийн төрлүүд хамрагдсан. Үүнд: Булган сумаас үзлэгт хамрагдах 8 өвийн зүйлийн 9 өвлөн уламжлагчийн бүртгэл гарсан. Үүнээс Үзлэг судалгаанд хамрагдаагүй 5. Судалгаанд нийт 4 өвлөн уламжлагчийг хээрийн үзлэг судалгаанд хамруулав.</p>				



99	2022.DoBu.Photo.Enkhtuvshin.A.Part1	2022.DoBu.Video.Enkhtuvshin.A.Part1	<p>Нэр: А.Энхтүвшин Ай сав: Ардын язгуур урлаг Өвийн нэр: Морин хуур хөгжмийн уламжлалт урлаг Баримтжуулсан тухай мэдээлэл: 1956 онд булган суманд төрсөн. Арслангийн Энхтүвшин гэдэг. Би уг сумандаа 35 жил соёлын төвийн эрхлэгчээр ажилласан. Морин хуурыг өөрийн мэдрэмжээр сурсан.</p>	
100	2022.DoBu.Photo.Badmagarav.S.Part1	2022.DoBu.Video.Badmagarav.S.Part1	<p>Нэр: С.Бадамгарав Ай сав: Мал маллах арга ухаан Өвийн нэр: Мал маллах арга ухаан Баримтжуулсан тухай мэдээлэл: Намайг саруул гүний хошуу Хэрээв овогт Санжаагийн Бадамгарав гэдэг. Би 1941 онд төрөөд хөдөө өсөж, торнисон. Улмаар 1962 онд Дорнод аймгийн Төвийн арван жилийг төгссөн. ХААИС хуваарилагдсан боловч ар гэрийн гачигдлаар хөдөө гарсан. 1962 оноос мал маллаж эхэлсэн. Туг нэгдэлдээ мал маллаж байсан. Мал сүргээ таван төрлөөр өсгөж, өндийлгөсөн. Мал маллаж байгаа хүн өвсний соргог, усны тунгалагыг тааруулан мал маллах хэрэгтэй байдаг. Байгалаа мэддэг байх ёстой юм.</p>	

101	2022.DoBu.Photo.Tsagaachin.J.Part1	2022.DoBu.Video.Tsagaachin.J.Part1	<p>Нэр: Ж. Цагаачин Ай сав: Ардын язгуур урлаг Өвийн нэр: Хурдан морины хүүхдийн гийнгоо, марзай Баримтжуулсан тухай мэдээлэл: Тухайн үеийн хоёр сумын алдарт уяач надад зааж өгсөн юм. Өглөө эрт морио хөнгөлөх зорилгоор марзайлдаг. “Марзай ном суу хай, богд өршөө” гэж марзайлдаг. Алхааны марзай гэдэг нь “Ум марзай Ум суу хай, гийнгоо богд өршөө, Цогионы марзай “марзай ном суу хай, гийнгоо богд өршөө” хэмээнэ.</p>	
102	2022.DoBu.Photo.Mungunsukh.U.Part1	2022.DoBu.Video.Mungunsukh.U.Part1	<p>Нэр: Ү. Мөнгөнсүх Ай сав: Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд Өвийн нэр: Цол дуудлага Баримтжуулсан тухай мэдээлэл: Намайг Үржингийн Мөнгөнсүх гэдэг. Би өөрийнхөө сонирхлоор морь бөхийн цол дуудаж сурсан.</p>	
<p style="text-align: center;">Хөлөнбуйр сум (DoKhuBu)</p> <p>Хөлөнбуйр суманд 11-р дүгээр сарын 6-нд ажиллав. Хөлөнбуйр сумаас үзлэг судалгаанд Жаранпай тоглоом, Хуанши тоглоом, Барга яндан гамбир, Барга халуун тогоо, Барга ардын урт дуу, Хулсан хуур хөгжим тоглох урлаг, Шагайн харваа, Ерөөл, магтаал зэрэг өвүүд хамрагдав. Хөлөнбуйр сумаас үзлэгт хамрагдах 17 өвийн зүйлийн 34 өвлөн уламжлагчийн бүртгэл гарсан. Үүнээс Үзлэг судалгаанд хамрагдаагүй 26. Судалгаанд нийт 8 өвлөн уламжлагчийг хээрийн үзлэг судалгаанд хамруулав</p>				

103	2022.DoKhuBu. Photo.Ulziibayar .G.Part1	2022.DoKhuBu.Video.Ulziibayar.G.Part1	<p>Нэр: Г.Өлзийбаяр Ай сав: Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага Өвийн нэр: Хөлөгт ба өрөгт тоглоомын уламжлалт төрлүүд Баримтжуулсан тухай мэдээлэл: Авгачууд овогтой Гомбын Өлзийбаяр. Манай өвөг дээдэс орой үдшийн цагаар тоглож ирсэн. Зав чөлөөтэй үед тоголдог тоглоом байгаа юм. “Жаран” буюу жаран ширхэг “пай” буюу “тэмдэгт” гэсэн утгатай тоглоом юм. Даалуунаас ялгаатай нь зургаан “ноён” модтой. Хамгийн том мод нь “сөрж”, “шанд”, “дун”, “өлзий”, “бэл”, “хас” зэрэг ноён модтой. Бусад тоогоороо доошоо явчихдаг.</p>	
104	2022.DoBu.Phot o.Chuluuntsetse g.G.Part1	2022.DoBu.Video.Chuluuntsetseg.G.Part1	<p>Нэр: Г.Чулуунцэцэг Ай сав: Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага Өвийн нэр: Цаасан болон модон тоглоомын уламжлалт төрлүүд Баримтжуулсан тухай мэдээлэл: 54 хэзрээр тоглодог. Багачууд, хүүхдүүдийн тооны ухаан, сэтгэхүйн ухааныг сорьсон тоглоом юм аа. Хоёр, гурав, дөрвөн хүн тоглож болдог. Гартаа байгаа модоо газарт байгаа модтой нийлүүлэн тооцож бодох ёстой бөгөөд алдаж тооцвол хэзрөө алддаг. Хамгийн олон цохил авсан нь хүн хождог.</p>	

105	2022.DoBu.Photo.Tsetsgee.Ts.Part1	2022.DoBu.Video.Tsetsgee.Ts.Part1	<p>Нэр: Ц.Цэцгээ Ай сав: Уламжлалт арга ухаан Өвийн нэр: Монгол үндэсний уламжлалт, цай ундаа хийх арга Баримтжуулсан тухай мэдээлэл: Намайг Харгана овгийн Цэвээнжавын Цэцгээ гэдэг. 71 настай. Нүүдлийн үед маш түргэн болгох зорилгоор анх хийж эхэлсэн гэдэг. Сүүлд дайны үед хамгийн их хэрэглэж байсан. Холын аянд явахад Бараг яндан гамбирыг халуун шөл, цайндаа хөшиглөж идэхэд сайхан амттай. Хир удаан хугацаанд хэрэглэсэн ч болно. Цагаан сараар өргөн дэлгэр хэрэглэж байна.</p>	
106	2022.DoBu.Photo.Tsetsgee.J.Part1	2022.DoBu.Video.Tsetsgee.J.Part1	<p>Нэр: Ж. Цэцгээ Ай сав: Уламжлалт арга ухаан Өвийн нэр: Монгол үндэсний уламжлалт, цай ундаа хийх арга Баримтжуулсан тухай мэдээлэл: Би авгачууд халтай (ястай). Жамбалын Цэцгээ гэдэг. Багш мэргэжилтэй. Манай Барга нар эрт дээр үеэс халуун тогоо ашиглаж ирсэн уламжлалтай. Эртнээс задгай гал хэрэглэж байсан. Задгай гал бол эрүүл мэндэд тустай. Эрч хүчээр тэтгэдэг гэж ярдаг. Гурван хөлтэй тулган дээр халуун тогоогоо тавиад галаасаа цогийн авч тогооныхоо доор байршуулаад тэгээд тогоогоо тавьж, таглаад хоол цайгаа халуунаар байлгадаг байжээ. Энэ үйл явц сүүлдээ халуун тогоон дээрээ цогоор цонгож олон төрлийн хоол хийж идэх болсон. Мөн талх барьж болно. Гэх мэт олон төрлөөр ашиглаж байна.</p>	

107	2022.DoBu.Photo.Ishinnorov.G.Part1	2022.DoBu.Video.Ishinnorov.G.Part1	<p>Нэр: Г.Ишноров Ай сав: Ардын язгуур урлаг Өвийн нэр: Буриад - Барга уртын дуу Баримтжуулсан тухай мэдээлэл: Намайг Цээхэр халтай (ястай) Гаваагийн Ичинноров гэдэг. Барга ястан. Би “Могой шинжийн орон” айзам уртын дуу дуулна. 1945 онд манай Барга түмэн Монгол улсад орж ирэх нүүдлийн замд зохиогдсон дуу юм гэнэ лээ. Энэ дууны үг нь яагаад Монголд нүүж ирсэн тухай ерөнхий учир шалтгааныг дурдсан байдаг.</p>	
108	2022.DoBu.Photo.Batzaya.D.Part1	2022.DoBu.Video.Batzaya.D.Part1	<p>Нэр: Д.Батзаяа Ай сав: Ардын язгуур урлаг Өвийн нэр: Хулсан хуур хөгжим тоглох урлаг Баримтжуулсан тухай мэдээлэл: тэрээр хулсан хуураас гадна морин хуур тоглодог. Намайг Доржжамцын Батзаяа гэдэг. Урианхай ястай. Халх угсаатны бүлгийн хүн байна. Гал шарын магтаал магтдаг. Тэрээр эдгээр өвийг өвөг эцгээсээ сурсан. Өвөг эцэг нь нүүдлэн ирж энэ нутагт суурьшсан.</p>	

109	2022.DoBu.Photo.Batbayr.Ch.Part1	2022.DoBu.Video.Batbayr.Ch.Part1	<p>Нэр: Ч.Батбаяр Ай сав: Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага Өвийн нэр: Шагайн харваа Баримтжуулсан тухай мэдээлэл: Намайг Шарайд хадлтай (ястай) Чулуунбаатарын Батбаяр гэдэг. Би өөрөө Барга угсаатны бүлгийн хүн. Хөлөнбуйр сумын нэгдүгээр багийн иргэн. Манай суманд 80-90 онд үндэсний шагайн харваа их дэлгэрсэн гэж үздэг.</p>	
110	2022.DoBu.Photo.Munkhgerel.Ts.Part1	2022.DoBu.Video.Munkhgerel.Ts.Part1	<p>Нэр: Ц.Мөнхгэрэл Ай сав: Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд Өвийн нэр: Ерөөл Баримтжуулсан тухай мэдээлэл: Намайг Цэрэндоогийн Мөнхгэрэл гэдэг. Авгачууд халтай. Найм төгсөөд барилгын ТМС-д сурсан. Одоогийн 20 жилийн өмнөөс ерөөл хэлж эхэлсэн. Таван хошуу малаа магтаж ерөөдөг. ТМС төгсөөд малчин болсон. Найр, наадам, хурим, гэрийн найр зэрэгт уригдан ерөөл хэлдэг болоод байна. Манай удмынхан хэлмэрч хүмүүс байсан гэдэг.</p>	

ХАВСРАЛТ

1. Хавсралт 1 - Удирдамж
2. Хавсралт 2 - Шинээр илрүүлсэн өвлөн уламжлагчдын жагсаалт
3. Хавсралт 3 – Соёлын биет бус өвийн үзлэг, судалгааны асуулгын маягт



**СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН ҮЗЛЭГ, БҮСЧИЛСЭН СУДАЛГААГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ**

НЭГ. ЗОРИЛГО

1.1. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.11 дэх хэсэг, 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт, Соёлын сайдын 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн "Зардал баталж, эрх шилжүүлэх тухай" А/218 дугаар тушаалыг үндэслэн "Соёлын биет бус өвийн үзлэг" (цаашид үзлэг гэх), бүсчилсэн судалгааг зохион байгуулах, СББӨ-ийг сурвалжлан олох, судалгаа шинжилгээ хийх, хадгалалт хамгаалалтын нөхцөл байдал, эерэг болон сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг судлах, тархалтыг тогтоох, үзлэгийн мөрөөр авах арга хэмжээний санал боловсруулах, шаардлагатай хэрэглэгдэхүүн, мэдээлэл цуглуулахад оршино.

Зохион байгуулагч: Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газар

Хамтран зохион байгуулагч: Соёлын өвийн үндэсний төв, аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар, аймаг, нийслэлийн Соёл, урлагийн газар

ХОЁР. ЗОРИЛТ

2.1. СББӨ-ийн уламжилсан байдал, шилжилт хөдөлгөөн, нийгэм, эдийн засаг, эрүүл мэндийн нөхцөл байдлын судалгаа хийх;

2.2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын "Бүртгэл шинэчлэн батлах тухай" 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/759 дүгээр тушаалаар баталсан Соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэл, Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэлд бүртгэгдсэн өв, өвлөн уламжлагчийн талаар түүвэр судалгаа хийх;

2.3. Тухайн орон нутагт оршин буй үндэстэн, угсаатны бүлэг, СББӨ-ийн төрөл зүйлийг таньж тогтоох, сурвалжлан олох;

2.4. Соёлын биет бус өв, өв тус бүрийн хадгалалт хамгаалалтын өнөөгийн нөхцөл байдал, эерэг болон сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг илрүүлж тогтоох, дүн шинжилгээ хийх;

2.5. СББӨ болон өвлөн уламжлагчийн тоо, газарзүйн тархалтыг тогтоох;

5. Уламжлалт арга ухаан;
6. Мал маллах арга ухаан;
7. Уламжлалт гар урлал.

(Тушаалын хавсралтыг Соёлын өвийн үндэсний төвийн <http://ncch.gov.mn/method> цахим хуудаснаас татаж авна уу.)

4.2. Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд анхан шатны байдлаар бүртгэгдсэн өвлөн уламжлагчийн бүртгэлд тулгуурлан зохион байгуулна.

4.3 СББӨ-ийн үзлэг, бүсчилсэн судалгааг Баруун, Зүүн, Хангайн, Төв, Говийн бүсийн дагуу зохион байгуулж, дараах байдлаар хамрах хүрээг тодорхойлно. Үүнд:

4.3.1 Баруун бүс буюу Ховд, Увс, Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан;

4.3.2 Хангайн бүс буюу Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Булган, Орхон, Хөвсгөл;

4.3.3 Төвийн бүс буюу Сэлэнгэ, Төв, Дархан-Уул;

4.3.4. Говийн бүс буюу Дорноговь, Дундговь, Өмнөговь, Говь-сүмбэр;

4.3.5 Зүүн бүс болон нийслэл буюу Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Улаанбаатар хот.

ТАВ. ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

5.1. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага СББӨ-ийн үзлэг, бүсчилсэн судалгааны ажлыг цахим болон хээрийн судалгааны аргаар тус тус зохион байгуулна;

5.2. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага үзлэг, судалгааг удирдлага зохион байгуулалтаар хангах "Төв ажлын хэсэг", Баруун, Зүүн бүс болон нийслэл, Хангайн, Төв, Говийн бүсийн нутаг дэвсгэрт ажиллах "Хээрийн судалгааны баг"-ийг тус тус байгуулна;

5.3. Аймаг, нийслэлийн Засаг дарга орон нутагтаа СББӨ-ийн үзлэг, судалгааг зохион байгуулах "Салбар ажлын хэсэг"-ийг байгуулна;

5.4. Үзлэг, судалгааны явцад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр "Төв ажлын хэсэг"-ийн дарга, гишүүд, "Хээрийн судалгааны баг"-ийн ахлагч, судлаач, "Салбар ажлын хэсэг"-ийн дарга, гишүүдийг өөрчилж, чөлөөлөхийг хориглоно;

5.5. Төв ажлын хэсэг

5.5.1. "Төв ажлын хэсэг" нь Баруун, Хангайн, Зүүн, Төв, Говийн бүсийн СББӨ-ийн үзлэг, судалгааг зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр хангах, дүн шинжилгээ хийх, судалгаа, тайланг нэгтгэх, тайлагнах, үзлэг, судалгааны ажлын мөрөөр авах арга хэмжээний санал боловсруулах ажлыг удирдан зохион байгуулна;

5.5.2. "Төв ажлын хэсэг" нь хээрийн судалгааны багийг ажлын маршрутыг гаргана;

5.5.3. "Төв Ажлын хэсэг" нь "Салбар ажлын хэсэг"-т баталсан асуулгын маягт 1, 2-ыг 2022 оны 10 дугаар сарын 15-ны өдөр цахим холбоосоор хүргүүлж, цахим маягыг бөглөх, заавар, сургалтыг зохион байгуулна.

5.5.4 "Төв ажлын хэсэг" нь цахим асуулгын маягт 1, 2-т оруулах мэдээлэл, зохион байгуулах үйл ажиллагаанд хяналт тавьж, "Салбар ажлын хэсэг"-ийг мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллана.

5.5.5. "Төв ажлын хэсэг" нь ажлын 21 хоног тутамд хуралдаж, "Хээрийн судалгааны баг", "Салбар ажлыг хэсэг"-ээс ирүүлсэн ажлын явц, үр дүнгийн талаарх мэдээлэлтэй танилцаж, холбогдох санал, зөвлөмжийг "Хээрийн судалгааны баг", "Салбар ажлыг хэсэг"-т тус тус хүргүүлж ажиллана;

5.6. Хээрийн судалгааны баг

5.6.1 СББӨ-ийн үзлэг, бүсчилсэн судалгааг зохион байгуулах "Хээрийн судалгааны баг" маршрутын дагуу томилолтоор ажиллахдаа түүврийн болон асуумжийн арга зүйг ашиглана;

5.6.2. СББӨ-ийн үзлэг, бүсчилсэн судалгааг бүсчлэн зохион байгуулах хээрийн судалгааны багийн бүрэлдэхүүнд тухайн орон нутгийн соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дэмжлэг үзүүлж хамтран ажиллах ба Соёлын өвийн асуудал хариуцсан мэргэжилтэн "Хээрийн судалгааны баг"-т ажиллана;

5.6.3. Засгийн газрын 2019 оны 475 дугаар тогтоолоор батлагдсан "Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалт"-д бүртгэгдсэн өвлөн уламжлагч, Монгол Улсын Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэлд багтсан өв, өвлөн уламжлагчийн урын сан, уламжлалт мэдлэг ухаан, арга барилыг "Хээрийн судалгааны баг" биечлэн үзэж гэрэл зураг, дуу, дүрс бичлэгээр баримтжуулна;

5.6.4. Гэрэл зургийн нягтаршлыг 300 dpi-аас доошгүй, JPG өргөтгөлтэй авах, дүрс бичлэгийг HD форматаар бичнэ;

5.6.5. Гэрэл зургийн тоо нь 3-с доошгүй /тухайн өвлөн уламжлагчийн холбогдох гэрэл зураг/, дүрс бичлэг нь 5 минутаас доошгүй байна;

5.6.6. СББӨ-ийн оршин тогтнох чадавх, нөхцөл байдлын дүн шинжилгээ, задлан шинжилгээ хийхдээ тоон болон харьцуулалтын аргыг ашиглана;

5.6.7. СББӨ, өвлөн уламжлагчийг гэрэл зураг, дүрс бичлэгээр баримтжуулахдаа тайзны болон уран сайхны, зохиомол байдлаас зайлсхийж, бодит үйл явдал, өрнөл, хөдөлгөөнт дүрслэл бүхий баримтат бүртгэн, баримжуулалтыг хийнэ.

5.7. Салбар ажлын хэсэг

5.7.1. Аймаг, нийслэлийн Засаг даргын тушаалаар СББӨ-ийн үзлэг, судалгааг зохион байгуулах “Салбар ажлын хэсэг”-ийн бүрэлдэхүүнийг батлана.

5.7.2. Соёлын биет бус өвийн үзлэг хийх журмын 2.5 дахь хэсэгт заасны дагуу бүх шатны Засаг дарга нар “Салбар ажлын хэсэг”-т шаардлагатай дэмжлэг үзүүлж хамтран ажиллана;

5.7.3. Аймгийн “Салбар ажлын хэсэг” нь 5-аас дээшгүй хүний бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

Дарга: Аймгийн соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга;

Гишүүд: Аймгийн Засаг даргын тамгын газрын нийгмийн бодлогын хэлтсийн соёлын асуудал хариуцсан мэргэжилтэн;

Аймгийн бүртгэл, мэдээллийн сан хариуцсан ажилтан эсхүл орон нутгийн музейн бүртгэл, мэдээллийн сан хариуцсан ажилтан;

Соёлын биет бус өвийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, эрдэмтэн, судлаачдын төлөөлөл;

Нарийн бичгийн дарга: Аймгийн соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын соёлын өвийн асуудал хариуцсан мэргэжилтэн.

5.7.4. Нийслэлийн “Салбар ажлын хэсэг” нь 5-аас дээшгүй хүний бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

Дарга: Нийслэлийн Соёл, урлагийн газрын дарга;

Гишүүд: Нийслэлийн Соёл, урлагийн газрын Соёлын хэлтсийн дарга;

Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн соёлын асуудал хариуцсан мэргэжилтэн ;

Соёлын биет бус өвийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, эрдэмтэн, судлаачдын төлөөлөлөл;

Нарийн бичгийн дарга: Нийслэлийн Соёл, урлагийн газрын соёлын өвийн асуудал хариуцсан мэргэжилтэн.

5.7.5. “Салбар ажлын хэсэг”-ийн дарга нь ажлын хэсгийн үйл ажиллагааг өдөр тутмын удирдлагаар хангаж, үзлэг, судалгааны ажлыг зохион байгуулах төлөвлөгөөг батлан, гишүүдийн хариуцах ажил үүргийг тогтооно;

5.7.6. “Салбар ажлын хэсэг”-ийн нарийн бичгийн дарга нь ажлын хэсгийн үйл ажиллагааг баримтжуулах, холбогдох баримт бичгийг цуглуулах, хадгалах, ажлын хэсгийн даргаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг хариуцна;

5.7.7. Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн соёлын асуудал хариуцсан мэргэжилтэн үзлэг, судалгааны ажлыг зохион байгуулахад шаардлагатай дэмжлэг үзүүлэх ажлыг хариуцна;

5.7.8. Соёлын биет бус өвийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, эрдэмтэн, судлаачдын төлөөлөл нь мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллана;

5.7.9. “Салбар ажлын хэсэг” нь Соёлын биет бус өвийн оршин тогтнох чадварыг тодорхойлох зорилгоор баталсан асуулга бүхий маягт, гэрэл зураг, дуу, дүрс бичлэгээр баримтжуулж, дүн шинжилгээ хийх байдлаар зохион байгуулна;

5.7.10. “Салбар ажлын хэсэг” нь СББӨ-ийн үзлэг, судалгааг удирдамжийн 3.2-т заасан хугацаанд асуулгын маягтын дагуу цахимаар зохион байгуулна.

5.7.11. “Салбар ажлын хэсэг” нь www.ich.mongoluv.mn програмд бүртгэлтэй өвлөн уламжлагч нарын мэдээлэлд үндэслэн батлагдсан цахим асуулгын маягт 1-ийн дагуу СББӨ-ийн өвлөн уламжлагч нараас асуулгыг авч мэдээллийг цахим (google form)-д оруулах, бүртгэл хөтлөх, ажлыг зохион байгуулна;

5.7.12. “Салбар ажлын хэсэг” нь СББӨ-ийг хадгалж хамгаалах чиглэлээр зохион байгуулагдсан арга хэмжээний судалгааг батлагдсан цахим асуулгын маягт 2-ын дагуу мэдээллийг цуглуулж цахим (google form)-д оруулна;

5.7.13. “Салбар ажлын хэсэг” нь 2 долоо хоног тутамд хуралдаж, үзлэг, судалгааны ажлын явцын талаар хэлэлцэж, явцыг илтгэх хуудсаар “Төв ажлын хэсэг”-т (цахимаар) ирүүлнэ;

ЗУРГАА. ЗОХИОН БАЙГУУЛАЛТАД БАРИМТЛАХ ЗАРЧИМ

6.1. Судалгаа, үзлэг, судалгааны ажлыг зохион байгуулахад шашин шүтлэг, нас, хүйс үл хамааран, угсаатны цөөнхийн тэгш оролцоог хангах зарчмын дагуу зохион байгуулна.

6.2. Тухайн бүс нутагт шилжин суурьшсан үндэстэн, угсаатны бүлгийн соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчийг тэгш хамруулна;

6.3. Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд анхан шатны байдлаар бүртгэгдсэн СББӨ, түүнийг өвлөн уламжлагчийг тухайн өвийн оршин байгаа газар,

ахуй орчин, шаардлагатай тохиолдолд нэг дор төвлөрүүлэн үзлэг, судалгааг зохион байгуулна;

6.4. Удирдлага зохион байгуулалтаар хангах ажлын хэсэг, Хээрийн судалгааны баг, Салбар ажлын хэсэг нь соёлын биет бус өвийн үзлэг, судалгааны үеэр олж авсан хувь хүн, албан байгууллагын нууцыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу чандлан нууцална;

6.5. Соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагч нь үнэ цэнийн хувьд шүүмжлэлээс ангид байна.

6.6. Тухайн соёлын биет бус өвийн үндсэн агуулгыг хувиргах, бүтцийг өөрчлөх, буруу ташаа ойлголт үүсгэхээс сэргийлнэ.

6.7. Өвлөн уламжлагчийн үнэт зүйлс, соёлын хэм хэмжээг хүндэтгэн хүлээн зөвшөөрч, угсаатны өвөрмөц байдлыг хүндэтгэх, жендэрийн тэгш байдалд онцгой анхаарал хандуулна.

6.8. Өвлөн уламжлагтай хамтын ажиллагаа, харилцан яриа хэлэлцээ, зөвшилцөл, зөвлөлдөх зарчмаар судалгаа, үзлэгийг зохион байгуулна.

ДОЛОО. СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙГ ӨВЛӨН УЛАМЖЛАГЧДЫГ ТАНЬЖ ТОГТООХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

7.1. Соёлын биет бус өвийг илэрхийлэх арга барил, язгуур хэв шинж, донж маяг, уламжлалыг хадгалсан байх;

7.2. Гүйцэтгэх ур чадвараараа нутаг усандаа алдаршсан байх;

7.3. Тухайн дэг сургууль, арга барилын гол төлөөлөгч, илтгүүр /эталон/ нь байх;

7.4. Соёлын орчин, ахуй зан үйлтэйгээ аль болох уялдсан байх;

7.5. Урын сан, ур чадвар, гүйцэтгэл, онцлогийг илэрхийлэх байдал;

7.6. Сургалт явуулах чадавх, дадлага туршлагатай байх;

7.7. Устаж мөхөхийн босгонд тулсан, яаралтай хамгаалалтад авах шаардлагатай өвийг онцгой харгалзах;

7.8. Тухайн өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөн эзэмшсэн байх;

7.9. Тухайн өвтэй холбогдох эд зүйл, хэрэглэгдэхүүн, хэрэглээ, давтамж зэргийг харгалзан үзнэ. *(өвлөн уламжлагчид нь дээрх шалгуур үзүүлэлтээс 2-оос доошгүй шалгуурыг хангасан байна).*

Шинээр илрүүлсэн өвлөн уламжлагчдын жагсаалт

№	Өвлөн уламжлагчийн нэрс	Дорнод аймгийн сумд	Ай сав	Өвийн төрөл
1	Ж.Мөнхжаргал	Матад	Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд	Цол дуудлага
2	Ч.Соль	Хэрлэн	Ардын язгуур урлаг	Халх уртын дуу
3	С.Сумьяа	Хэрлэн		Халх уртын дуу
4	Д.Мягмар	Хэрлэн		Халх уртын дуу
5	Ч.Энхтуяа	Хэрлэн		Халх уртын дуу
6	Б.Мягмар	Хэрлэн		Буриад уртын дуу
7	Г.Дэндэв	Хэрлэн		Монгол Хөөмийн уламжлалт урлаг
8	Д.Гэрэлбат	Хэрлэн		Уламжлалт арга ухаан
9	Д.Гансүх	Чойбалсан сум	Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага	Уул, овоо тахих зан үйл
10	Н.Пүрэвсүрэн	Чойбалсан сум	Уламжлалт гар урлал	Монгол дархны уламжлалт арга ухаан
11	Ж.Цэвээнрэгзэн		Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд	Хууч яриа
12	Ж.Будханд	Гурванзагал	Уламжлалт арга ухаан	Мал хатгах уламжлалт мэдлэг
13	Х.Цагаан	Гурванзагал	Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага	Мал аж ахуйн холбогдолтой уриа дуудлага
14	Ч.Ганбаатар	Гурванзагал	Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд	Цол дуудлага
15	Ч.Жаргалмаа	Гурванзагал	Уламжлалт арга ухаан	Монгол үндэсний уламжлалт, цай ундаа хийх арга
16	Н.Гантөмөр		Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага	Уул, овоо тахих зан үйл

17	Д.Даваахүү	Чулуунхороот	Уламжлалт гар урлал	Монголын уламжлалт модон эдлэлийн урлал.
18	Б.Цэвээндорж	Чулуунхороот	Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага	Шагайн харваа
19	М.Наранболд	Дашбалбар	Уламжлалт арга ухаан	Бариа заслын аргаар анагаах арга ухаан
20	Ю.Саранхуяг	Дашбалбар	Уламжлалт гар урлал	Морин хуур хөгжмийн уламжлалт урлаг
21	Ц.Чимэджав	Дашбалбар	Ардын язгуур урлаг	Буриад богино дуу
22	Л.Раднаацэрэн	Баяндун		Буриад богино дуу
23	Н.Батбаяр	Баяндун	Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд	Цол дуудлага
24	Г.Цэдэнбаяр	Баяндун	Ардын язгуур урлаг	Харилцаа дуу
25	З.Оюун	Баяндун		Буриад богино дуу
26	Д.Оюунчимэг	Баян-Уул	Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд	Буриад аман аялгуу
27	Д.Энхзаяа	Сэргэлэн	Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд	Магтаал
28	Ц.Төмөрбаатар	Сэргэлэн	Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд	Хууч яриа
29	Ү.Мөнгөнсүх	Булган	Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд	Цол дуудлага
30	Ц.Цэцгээ	Хөлөнбуйр	Уламжлалт арга ухаан	Монгол үндэсний уламжлалт, цай ундаа хийх арга
31	Ж.Цэцгээ	Хөлөнбуйр	Уламжлалт арга ухаан	Монгол үндэсний уламжлалт, цай ундаа хийх арга

